

---

Хоригдогсдын **ХҮН**  
гэсэн нэр төрийг нь  
**ХҮНДЭТГЭН**  
харьцах ёстой

---

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ГАРЧИГ

1. Хоригдогсодтой харилцах.....	4
- Эрүү шүүлт ба хүнлэг бусаар харьцах хандлага	
- Ганцаарчилан хорих	
- Тусгай хэрэгсэл	
2. Гадаад ертөнцтэй харилцах .....	10
3. Материаллаг нөхцөл .....	13
- Хоол хүнс, ундны ус	
- Гэрэлтүүлэг ба агааржуулалт	
- Эрүүл ахуйн нөхцөл	
- Хувийн ариун цэвэр	
- Хувцас, цагаан хэрэглэл	
4. Боловсрол сургалт.....	20
5. Дэглэм ба хамгаалалтын арга хэмжээ.....	24
- Хоригдож байгаа этгээдийн ангилал	
- Хоригдож буй этгээдийг зохистой байршуулах	
- Хамгаалалтын арга хэмжээнүүд	
- Хяналт шалгалт	
- Сахилгын арга хэмжээ	
- Гомдол гаргах журам	
6. Эрүүл мэндийн үйлчилгээ.....	35
- Эмнэлгийн үйлчилгээ авах боломж	
- Эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмнэлгийн үйлчилгээ	
- Эмнэлгийн боловсон хүчин	
7. Ашигтай хөдөлмөр.....	41
8. Хорих, цагдан хорих газрын албан хаагчид.....	42
9. Цагдаагийн байгууллагад саатуулах.....	46
- Аюулгүй байдлын үндсэн баталгаа	
- Баримтжуулалт	
- Байцаалт	
- Мэдээлэл	
- Материаллаг нөхцөл	

## **ӨМНӨХ ҮГ**

Хүмүүс нийгэмд болоод иргэдэд гэм хор учруулсныхаа төлөө шалгагдаж, саатуулагдах, эсхүл гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө баривчлагдан хоригдохдоо зарим эрхээ хуулийн дагуу хязгаарлуулдаг. Эрх нь хязгаарлагдсан хүн, нөгөө талаас төрийн нэрийн өмнөөс ажил үүрэг гүйцэтгэдэг өндөр цалинтай, цол хэргэм, дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий ажилтан хоёрын дунд тэгш бус харилцаа үүсэх эрсдэл өндөр бөгөөд үүнээс урьдчилан сэргийлж НҮБ-аас эрүүдэн шүүх, хүнлэг бусаар доромжлон харьцахаас хамгаалсан тунхаглал, конвенц, Аливаа хэлбэрээр хоригдсон саатуулагдсан хүнийг хамгаалах, Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм, зарчмуудыг батлан гаргаснаас хойш 60 жил болжээ.

Эдгээр баримт бичиг, жишиг дүрмүүд хэрэгжих хугацаанд дэлхий нийтээрээ нэг ойлголтонд хүрч, дагаж мөрдөж байгаа гэвэл хараахан тийм биш юм. Иймээс баримт бичгүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, баталгаажуулах зорилгоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг батлан гаргаж, олон улс орон нэгдэн ороод байна. Монгол улс ч эрүүдэн шүүхийг гэмт хэрэг гэж үзэн НҮБ-ын холбогдох конвенцид нэгдэн орсон бөгөөд түүний Нэмэлт Протоколд нэгдэн орох асуудлыг ч судлан үзэж байна. Үүнтэй холбогдуулан Монголын Эмнести Интернэшнл болон Эрүүдэн Шүүхээс Урьдчилан Сэргийлэх Нийгэмлэгтэй хамтран “Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг” төслийн хүрээнд хорих байгууллагын ажилтнуудад зориулсан гарын авлага гаргаад байна. Энэ гарын авлага нь Хорих, цагдан хорих байгууллагад тавигддаг олон улсын болон бүс нутгийн стандартыг хялбаршуулан таниулахын зэрэгцээ үндэсний хууль тогтоомжоо хүртэл эргэн харж, юуг анхаарвал зохистойг санал болгосон юм. Гарын авлагад сэжигтэн, яллагдагч, баривчлагдсан хүмүүс, хоригдол зэргийг нэр томъёоны хувьд хоригдогч, хоригдогсод гэж авсан болно.

Тус ном Хоригдогсодтой харилцах, Гадаад ертөнцтэй харилцах, Материаллаг нөхцөл байдал, Боловсрол сургалт, Дэглэм хамгаалалтын арга хэмжээ, Эмнэлгийн үйлчилгээ, Ашигтай хөдөлмөр, Хорих газрын албан хаагчид гэсэн үндсэн бүлгүүдтэй.

### **Монголын Эмнести Интернэшнл**

Хялбаршуулан бэлтгэсэн

Б.Алтантуяа

Р.Оюунбадам

Д.Оюунномин

## **ХОРИГДОГСДОТой ХАРИЛЦАХ**

Хоригдож буй этгээд эмзэг бүлэгт хамаарагддаг. Иймд бүх төрлөөр хоригдож байгаа хүмүүстэй хүн гэдэг нэр төрийг нь хүндэтгэж, хүнлэг энэрэнгүй харьцах учиртай.

Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон шийтгэхийг хориглосон арга хэмжээг заавал дагаж мөрдөх ёстой зүйл бөгөөд түүнийг зөрчсөн тохиолдлыг ямар ч нөхцөл байдлаар зөвтгөх аргагүй юм. Хууль бусаар авч хэрэглэсэн арга хэмжээг хэрцгий, хүнлэг бус харьцсантай адилтгаж үзнэ.

Зохих ёсоор сонгогдож бэлтгэгдсэн, хоригдогсодтой яаж зөв харилцаа тогтоох болон өөрийн ажлаа зөвхөн ажлын байр төдийгөөр бус харин мэргэжлийн түвшинд тавьж чаддаг боловсон хүчинтэй байх нь шоронгийн хүмүүнлэг тогтолцооны тулгын чулуу билээ. Харамсалтай нь албан хаагчид болон хоригдогсдын хооронд ёс төдий, алслагдсан шинжтэй харьцаа тогтож, хоригдогсодтой үгээр харилцахыг ёс бус зүйл мэт үздэг байдал гарсаар байна. Тухайлбал хоригдогч албан хаагчийг дуудтал, эсхүл бусад хүмүүсийг явж өнгөртөл хана руу харж зогсох, толгойгоо гудайлгах, нуруугаа ардаа үүрэх, албан хаагч бороохойгоо илт гайхуулсан эсхүл илт өдсөн шинжтэй барьж явах гэх мэт. Аюулгүй байдлыг хангах үүднээс ингэх шаардлагагүй тул энэ нь албан хаагч, хоригдогсдын дунд сөрөг харилцаа үүсгэдэг. Хоригдогсодтой харилцах жишиг хэмжээг зөв зохистой дагаж мөрдөх нь харилцан итгэлцэл, хүнлэл бий болгох, тайван орчин бүрдүүлэх, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцахаас урьдчилэн сэргийлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

### **Хоригдогсодтой харьцахад хориглосон харилцаа**

- Эрүү шүүлт ба хэрцгий, хүнлэг бусаар харьцах хандлага
- Ганцаарчилан хорих
- Элдэв хориг, хязгаарлалт хийх арга хэрэгслүүд

## **ЭРҮҮ ШҮҮЛТ БА ХҮНЛЭГ БУСААР ХАРЬЦАХ ХАНДЛАГА**

Саатуулагдсан буюу хоригдсон нэг ч хүнийг эрүүдэж шүүх буюу хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэж болохгүй. Эрүүдэн шүүх, хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг ямар ч нөхцөл байдал зөвтгөж чадахгүй...”

(Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогцын 6 дугаар зарчим)

“Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэнтэй ч хэрцгий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хэн дээр ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийж болохгүй.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 7 дугаар зүйл)

Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хүний ёсноос гадуур эсхүл, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхийг хориглоно.

(Европын зөвлөлөөс 1950 онд баталсан Европын хүний эрхийн Конвенцийн 3 дугаар зүйл)

Эрүүдэн шүүх гэж төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд өөрөө, эсвэл түүний өдөөн хатгаснаар буюу ил, далд зөвшөөрлөөр хэн нэгэн этгээдийг өөрөөс нь буюу гурав дахь этгээдээс мэдээлэл авах, хэрэг хүлээлгэх, үйлдсэн буюу үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх, албадах, аливаа үндэслэлээр ялгаварлан гадуурхах шалтгаанаар бие махбод, сэтгэл санааны хувьд санаатайгаар хүчтэй өвтгөх, шаналгах аливаа үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолтод гагцхүү хуулийн цээрлэлийн үр дүнд болон түүнтэй салшгүй холбоотойгоор, эсвэл түүнээс тохиолдлоор үүдсэн өвдөлт, шаналлыг хамааруулахгүй.

(Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенцийн 1 дүгээр зүйл)

Хоригдогч хоригдогчоо хүчирхийлэхээс урьдчилан сэргийлэх, эмзэг, дорой хоригдогч нарт хамгаалалт, хяналт тавих ёстой. Ийм хэрэг гарвал зохих ёсоор таслан зогсоох, шийдвэрлэхэд албан хаагчид бэлтгэгдсэн байх нь чухал.

---

***Анхаарах зүйл:** Төрийн албан хаагч өөрөө эсвэл өөр хэн нэгэн этгээдээр хийлгэх зүй бус харилцаа, аливаа үйлдэл, мөн хоригдож байгаа этгээдүүдийн дунд гардаг сэтгэл зүйн болон бие махбодийн хүчирхийллийн хэлбэр нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанд тооцогддог тул анхаарахгүй өнгөрч болохгүй юм. Засан хүмүүжүүлэх тусгай байгууллагад байгаа насанд хүрээгүй хоригдогсодтой харьцах харилцаанд онцгой анхаарал хандуулвал зохинo.*

---

### **Шалгах асуулт**

- Биелүүлж гүйцэтгэхэд бэрхшээлтэй шаардлага тавигддаг уу?
- Өгөгдсөн ажлыг дуусгаж амжаагүй байхад дараа хийгдэх ажлыг зааж яаравчлуулдаг уу?
- Өөрийн ойлгоогүй зүйлийг дахин давтан лавлан асуудаг уу?
- Өөрийн санал хүсэлтийг ангийн удирдлага, эрх бүхий хүмүүст хүргэх бололцоотой юу?
- Өөрийн эрх үүрэг болон хорих ангийн дотоод дүрмийг үзэж танилцах, хүссэн үедээ тодруулах боломжтой юу?

### **Хоригдогсод хоорондын харилцаа**

- Хамт байрлагсадаасаа таагүй байдлыг мэдэрдэг үү? Тийм бол яагаад?
- Хоригдогсодын дунд гарах зөрчил маргаан юунаас болдог вэ?
- Хариуцан хийж байгаа ажил үүргээсээ болоод ямар нэг маргаан дарамтад (ятгалгад) ордог уу?
- Ямар нэг хувийн санал хүсэлтийг биелүүлэхэд хүндрэлтэйгээс татгалзахад зөрчил гардаг уу?

## **ГАНЦААРЧИЛАН ХОРИХ**

“Хоригдогчийг сахилгын байранд хорьж шийтгэх, түүнчлэн хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлөх бусад шийтгэл оногдуулахдаа зөвхөн эмч үзлэг хийж, ийм төрлийн шийтгэлийг давж гарна гэж бичгээр дүгнэлт хийсэн тохиолдолд хэрэгжүүлнэ”

(Европын шоронгийн дүрэм, 38 дахь дүрэм)

Хороо нь ямар нэг шалтгаанаар сахилгын шийтгэл ногдуулах журмаар хоригдогчийн тайван бус зан үйлийн улмаас, мөнмөрдөн байцаалтын нөхцөл байдлаас ганцаарчлан хоригдож байгаа этгээдэд анхаарал тавих шаардлагатай.

Тэнцвэртэй байх зарчмын үүднээс ганцаарчилан хорих асуудлыг зөвтгөж болох боловч үр дагавар талаас нь авч үзвэл зарим тохиолдолд ийнхүү ганцаарчлан хорих нь хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах харьцаатай ижил болно. Ямар ч тохиолдолд ганцаарчилан хорих бүх хэлбэрийг хэрэглэхдээ хорих хугацаа хамгийн бага байхаар тооцох нь зүйтэй.

Хоригдогчийн өөрийнх нь хүсэлтээр ганцаарчилан хорих аргыг хэрэглэх тохиолдолд хоригдогч өөрөө буюу түүний нэрийн өмнөөс хорих, цагдан хорих газрын албан хаагч эмч дуудвал эмч саадгүй ирж тухайн хоригдогчид эмнэлгийн үзлэг хийх шаардлагатай. Үзлэг хийсэн тухай тайланд хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл санааны байдал, шаардлагатай бол цаашид ганцаарчилан хорьсоноос үүдэн гарч болох үр дагаврын талаар бичиж эрх мэдэл бүхий байгууллага, албан тушаалтанд илгээнэ”

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 56)

“Шүүхээс ганцаарчилан хорих ялыг оногдуулах ёсгүй бөгөөд тухайн байгууллагын дотоод журмыг зөрчсөн тохиолдолд оногдуулах уг шийтгэл 2-оос илүүгүй өдөр байвал зохино” хэмээн Эрүүдэн шүүхийн асуудлаархи Тусгай илтгэгч тэмдэглэсэн байдаг.

---

*Анхаарах зүйл: Аль ч тохиолдолд ганцаарчлан хорих нь хүнд төрлийн шийтгэл бөгөөд түүнийг урт хугацаагаар юмуу байнга давтан хэрэгжүүлэх нь эрүүдэн шүүх хэлбэр гэж үздэг. Тиймээс энэ аргыг маш онцгой, зайлшгүй тохиолдолд хэрэглэх бөгөөд үргэлжлэх хугацаа нь богино байх ёстой.*

---

### **Шалгах асуулт**

- Ямар зөрчил, шалтгааны үндсэн дээр сахилгын байранд ганцаарчлан хорьдог вэ?
- Сахилгын байранд тусгаарлах хамгийн дээд хугацаа ямар байх ёстой вэ?
- Ганцаарчилан хорих шийдвэрийг хэн, ямар албан тушаалтан гаргах эрхтэй вэ?
- Эрх бүхий хүн байхгүй байх тохиолдолд шийтгэлийг хойшлуулдаг уу?
- Сахилгын байранд тусгаарлагдсан хоригдогчийг өдөр бүр нэг цаг эрүү

агаарт байлгадаг уу?

- Ганцаарчилан хорихын өмнө мөн дараа нь эмнэлгийн үзлэгт оруулдаг уу? Хоригдож байх үед тогтмол үзлэг хийдэг үү?
- Ганцаарчилан хоригдож байгаа хоригдогчийн хүсэлтээр эмчийн үзлэгт хамруулдаг уу?
- Ганцаарчилан хорих шийтгэлийг хугацаанаас нь өмнө цуцлах шаардлага байдаг уу? Тийм бол ямар тохиолдолд вэ? Танай анги дээр ийм зүйл гарч байсан уу?
- Ганцаарчилан хорих шийтгэлийн дараа эмчээс өөрөөр удирдах албан тушаалтан болон нийгмийн ажилтан уулздаг уу?
- Ганцаарчилан хоригдож байгаа хоригдогчийн эргэлт уулзалтыг оруулдаг уу?
- Ганцаарчилан хоригдож байгаа хоригдолд хоол, цай хасах, (жирийн үеийнхээс багасгах) салхинд гаргахгүй байх гэх мэт ахуйн шийтгэлийг оногдуулдаг уу?

## **ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ**

Гав, дөнгө, номхруулах цамц болон гинжийг шийтгэлийн журмаар хэзээ ч хэрэглэж болохгүй. Үүнээс гадна дөнгө болон гинжийг номхруулах хэрэгсэл болгон хэрэглэж огт болохгүй. Зөвхөн дор дурдсан тохиолдолд тусгай хэрэгсэл ашиглаж болно. Үүнд:

а/ хоригдогсдыг шүүхийн болон захиргааны байгууллагад тээвэрлэн хүргэх үеэр оргохоос урьдчилан сэргийлэх зорилгоор

б/ эмчийн заавраар

в/ хоригдогч өөртөө болон өрөөл бусдад хор уршиг учруулах гээд байгаа тохиолдолд хорих, цагдан хорих газрын дарга яаралтай эмчтэй зөвлөлдөж, удирдах дээд байгууллагад энэ тухай мэдэгдсэний дараа тушаал гаргаж хэрэглэж болох юм.

(Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм 33, 34 дүгээр дүрмийг үз)

“Гинж ба дөнгө хэрэглэхийг хориглоно. Гав, номхруулах цамц ба хүний хөдөлгөөнийг хориглосон бусад ийм төрлийн хэрэгслүүдийг ямар ч тохиолдолд шийтгэлийн журмаар хэрэглэхийг хориглоно. Зөвхөн дараахь тохиолдлуудад хэрэглэж болно. Үүнд:

а/ хоригдогчийг захиргааны болон шүүхийн байгууллагад хүргэхээр тээвэрлэх үед тухайн байгууллагуудад очсон хойноо тайлах нөхцөлтэйгээр хэрвээ тухайн байгууллагууд өөр журам тогтоогоогүй бол оргож болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор

б/ эрүүл мэндийн шалтгаанаар эмчийн заавраар, эмчийн хяналтан дор

в/ Хоригдогч өөртөө болон өрөөл бусдад бие махбодийн гэмтэл болон ноцтой хэмжээгээр эд материалын хохирол учруулах гээд байгаа тохиолдолд өөр арга хэмжээ үйлчлэхгүй бол хорих, цагдан хорих газрын дарга яаралтай эмчтэй зөвлөлдөж, удирдах дээд байгууллагад энэ тухай илтгэсний дараа тушаал гарган хэрэгжүүлж болох юм.”

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

“Өмнөх дурьдсан зүйл дээр зөвшөөрөгдсөн тусгай хэрэгслийг хэрэглэх аргыг хууль ба холбогдох эрх зүйн актаар тодорхойлно. Тэдгээрийг хэрэглэх хугацаа нь шаардлагатай хэмжээнээс хэрхэвч хэтэрч болохгүй”.

(Европын шоронгийн дүрэм, 39, 40 дэх зүйл )

Шоронгийн ажилтнууд хүчирхийлэл үйлдэж байгаа хоригдогчид, хяналт тогтоох зорилгоор зарим тохиолдолд хүч хэрэглэхээс өөр аргагүйд хүрч болно. Ийм тохиолдол хүний эрхийг зөрчихгүй байх онцгой баталгаа шаарддаг.

Бие махбодийн хувьд хүч хэрэглүүлсэн хоригдогч богино хугацаанд эмчид үзүүлэх, шаардлагатай үед эмчилгээ хийлгэх эрх эдлэх ёстой. Эмчийн үзлэгийг эмнэлгийн бус бусад ажилтны нүднээс далд хийх ёстой. Үзлэгийн дүнгийн тухай албан ёсоор тэмдэглэл хөтөлж хоригдсон этгээдэд үзүүлнэ. Бие махбодид нөлөөлөх хэрэгсэл хэрэглэх шаардлага ховор тохиолдох бөгөөд энэ хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд тухайн хоригдогчийг зохих ёсны байнгын хяналтад байлгах хэрэгтэй. Үүнээс гадна хамгийн анхны боломж гарсан тохиолдолд албадлагын эдгээр хэрэгслийг хэрэглэхийг хориглох ёстой. Эдгээрийг хэзээ ч шийтгэлийн журмаар ашиглаж болохгүй. Хоригдогчид хүч хэрэглэсэн тохиолдол бүрийг тэмдэглэж байх шаардлагатай.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 53)

“Хорих, цагдан хорих газрын ажилтан өөрийгөө хамгаалах аргагүй байдалд орсон, оргохыг завдсан тохиолдлыг таслан зогсоох, хоригдогсод хууль, дотоод журамд үндэслэсэн тушаалыг идэвхитэй болон идэвхигүй аргаар эсэргүүцсэн зэрэг тохиолдолд хүч хэрэглэж болно. Хүч хэрэглэсэн албан хаагч зайлшгүй шаардлагатай хүрээнд, тийм цаг хугацаанд тусгай хэрэгсэл хэрэглээд зогсох ёстой бөгөөд энэ тухайгаа байгууллагын удирдлагад яаралтай танилцуулах ёстой.”

(Европын шоронгийн дүрэм, 63 дахь зүйл)

---

**Анхаарах зүйл:** Тусгай хэрэгсэл хэрэглэх тохиолдолд зөвхөн хуулинд заасны дагуу хэрэглэх бөгөөд эсэргүүцэл зогсонгуут дуусгавар болгох ёстой. Тусгай хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан зориулалтын зүйл байх ёстой бөгөөд ямар нэг эд зүйлээр орлуулан хэрэглэхийг хориглоно.

---

### **Шалгах асуулт**

- Бүх албан хаагчид хүч ба тусгай хэрэгсэлийг хэрхэн ашиглах талаархи сургалтанд хамрагдсан уу? Ямар давтамжтай хамрагддаг вэ?
- Тусгай хэрэглэсэн бүх тохиолдлын талаар бүрэн тэмдэглэл хөтөлж, удирдах албан тушаалтандаа мэдэгддэг үү?
- Тусгай хэрэгсэл хэрэглэсэнээс болж албан хаагч өөрөө ямар нэг шийтгэлд өртдөг үү?
- Тусгай хэрэгсэл хүртээмжтэй, стандартад нийцсэн байж чаддаг уу?
- Тусгай хэрэгсэлийн ашиглахдаа хуульд заасан үндэслэл журмыг хэрэглэдэг үү?
- Эсэргүүцэл зогссон байсан ч хашраах, шийтгэх зорилгоор тусгай хэрэгслийг хэрэглэх үе байдаг уу?



- Тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа хоригдогч этгээд эмчийн үзлэгт ордог уу? Ганцаарчилан үзүүлдэг үү? Тухай бүрт эмчийн бүртгэл хөтлөгддөг үү? Түүнийг хэн хянаж шалгадаг вэ?

### **Нэмж унших материал**

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
  - НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр 1984 онд батлан гаргасан “ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенц
  - НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмын цогц”
  - Европын Зөвлөлөөс 1950 онд баталсан Европын Хүний Эрхийн Конвенц
  - Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм,
  - Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн тухай Монгол Улсын хууль
  - ХЗДХ-ийн сайдын 2008 оны 50 тоот тушаал
  - Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь, 2005 он. Эмнести Интернэшнл
  - Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын хүний эрхийн талаар баримтлах 10 үндсэн жишиг хэмжээ, 2000 он. Эмнести Интернэшнл
  - Цагдаагийн зэвсэг тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик, 2006 он.
3. Цэрэнбат
- Хуульчийн болон мэргэжлийн ёс зүйн дүрмүүд
  - НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрмүүд/
  - Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх, 1996 он, НҮБ
  - Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь, 2004 он. Эмнести Интернэшнл

## **ГАДААД ЕРТӨНЦТЭЙ ХАРИЛЦАХ**

Хоригдогсод гадаад орчинтой холбогдох, гаднаас тэдэнтэй холбоо барих боломжтой байх явдал нь эрүү шүүлт, зүй бусаар харьцахын эсрэг гол хамгаалалт юм. Хоригдогсод нь шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл журам болон өөрийнхөө эрх үүрэг, хязгаарлалын талаар мэдээлэл авах эрхтэй байдаг тул тэдэнд тайлбарлаж өгөх, эсхүл мэдээллээр хангах нь хорих байгууллагын ажилтнуудын үүрэг юм. Хоригдогсдын гадаад ертөнцтэй харьцах харилцаа нь гэр бүлээр хязгаарлах ёсгүй бөгөөд найз нөхөд, бусад танилуудтайгаа ч харилцдаг байх нь чухал. Хоригдогсод гэртээ чөлөөгөөр гарах, түр хугацаанд батлан даалтаар гарах, радио сонсох, зурагт үзэх зэрэг боломжоор хангагдах нь гадаад ертөнцтэй харилцах томоохон хамгаалалт юм.

### **Гадаад ертөнцтэй харилцах**

- Хоригдогсдыг мэдээллээр хангах
- Эргэлт, уулзалт, Зөвшилцөл ба утсан харилцаа ашиглах боломж
- Чөлөө олгох, түр нөхцөлөөр чөлөөлөх
- Ном сонин унших, мэдээллийн суваг хүлээн авах

## **ХОРИГДОГСДЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ**

Аливаа этгээдэд түүний эрхийг болон түүнийг хэрэгжүүлэх журмын талаар түүнийг баривчлах үед, саатуулах болон хорихын өмнө эсхүл дараа нь нэн даруй уг баривчлах, саатуулах, хорих ажиллагааг хариуцах байгууллага мэдэгдэж тайлбарлан ойлгуулах ёстой”

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 13 дугаар зарчим)

1/ Хоригдол бүрийг хорих ангид хүлээж авахдаа тухай төрлийн хоригдлуудтай харилцах журам, сахилгын шаардлага, түүнчлэн мэдээлэл авах, зөвшөөрөгдсөн эд зүйл, гомдол гаргах журам болон өөрийн эрх үүргээ мэдэх, амьдралын нөхцөлд дасахтай холбогдсон бусад асуудлаар мэдээллийг бичгээр өгнө.

2/ Бичиг үсэг мэддэггүй хоригдолд амаар танилцуулна.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 35 дугаар дүрэм

---

**Анхаарах зүйл:** Хорих газрын албан хаагчид нь гэр бүл, дотны хүнтэйгээ харилцах хоригдогчийн язгуур эрхийг хязгаарласан ямар нэгэн сахилгын шийтгэл оногдуулахгүй байвал зохино. Хоригдогчийн гэр бүлийнхэн тухайн хорих, цагдан хорих газрын дүрэм журам, ажлын талаар, ялангуяа эргэлт уулзалт, захидал харилцаа, илгээмж авах, утсаар харилцах, шаардлагатай бол хариуцсан албан хаагчаас хэрэгтэй зүйлээ хэрхэн тодруулах асуудлаар мэдээлэлтэй байх ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Шинээр ирсэн хоригдогч ямар мэдээлэл авах ёстой вэ? Мэдээлэл ямар хэлбэртэй байдаг вэ?
- Ойлгомжтой хэл дээр байсан уу? Бичиг үсэг мэддэггүй хүний ашиг сонирхлыг харгалзан үздэг үү?
- Хорих, цагдан хорих газрын дотоод журам, ялтны эрх үүргийн талаархи мэдээлэл нүдэнд ил харагдахаар болон хүссэн үедээ танилцах лавлан харах боломжтой газар байдаг уу?
- Дотоод журмын агуулга нь хоригдогсодтой харьцах стандартад нийцсэн үү?
- Дотоод журмын агуулга ойлгомжтой тодорхой байж чаддаг уу?
- Энэ ангид шилжин ирсэнийг ар гэрийнхэнд хэдий хугацаанд мэдэгдсэн бэ?
- Ангийн дотоод журам онцлог, эргэлтийн хуваарь нөхцлийг хоригдлын гэр бүлийнхэнд танилцуулдаг уу?

### **ЭРГЭЛТ, УУЛЗАЛТ, ЗАХИДАЛ БА УТСАН ХАРИЛЦАА**

Саатуулагдсан болон хоригдсон этгээд тухайлбал гэр бүлийн гишүүдтэйгээ уулзах, тэдэнтэй захидлаар харилцах, түүнчлэн хуулиар буюу хуульд нийцүүлж тогтоосон гадаад орчинтой харилцах эрхтэй.

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 19 дүгээр зарчим)

Хоригдлуудад тогтмол цаг хугацаанд, зохих хяналтын дор гэр бүлийнхэнтэйгээ болон найз нөхөдтэйгээ захидлаар харилцаж буюу биечлэн уулзаж харилцах боломж олгож байвал зохино.

(НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаарх анхны их хурал дээр 1955 онд баталсан “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 37 дугаар дүрэм)

Хоригдогсод гадаад ертөнцтэй сайн харилцаатай байхыг дэмжих нь маш чухал. Юуны түрүүнд хоригдогсод гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцаагаа таслахгүй байх боломж олгох нь зүйтэй. Гадаад ертөнцтэй холбоотой байхад нь дэмжлэг үзүүлэхийг удирдах зарчмаа болгох хэрэгтэй. Зөвхөн аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс болон материаллаг нөөцийн хангамж дутмаг байдлаас шалтгаалан ийм харилцаанд ямар нэг хязгаарлалт байж болох юм.

Гэр бүл нь алс хол оршин суудаг тэр бүр ирж уулзаад байж чаддаггүй хоригдогсод утсаар холбоо тогтоох, эргэлт уулзалт авах журмыг ашиглахад нь зарим нэгэн уян хатан байдал байх хэрэгтэй гэж тэмдэглэхийг хүсч байна. Жишээ нь, ийм хоригдогчид уулзалтын цагийг нь хадгалах, эсхүл гэр бүлийнхэнтэйгээ утсаар ярих сайжруулсан боломж олгож болох юм.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 51)

Хоригдогч нь хуульд заасны дагуу төрөл садантайгаа удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, утас захидлаар харилцах илгээмж авах өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулга авах, явуулах эрхтэй байдаг. Гэхдээ жирийн дэглэмтэй, насанд хүрээгүй ба насанд хүрсэн хоригдогсод түр хугацааны уулзалтыг ажлын 5 өдөрт хийнэ. Чанга, онцгой, гяндангийн дэглэмтэй буюу цагдан хоригдож буй хоригдогсод түр уулзалт тодорхой хэмжээний хязгаарлалттай байдаг.

Уулзалтын нөхцөл нь аюулгүй байдлын шаардлага ба хүний нэр төрийг хүндэтгэхэд нийцсэн байх ёстой. Гэр бүлийнхэнтэйгээ тусдаа уулзах өрөө тасалгаа бий болгох асуудлыг дэмжих ёстой. Хоригдож буй гадаадын иргэд нь ямар нэг дэмжлэггүй үлдчих магадлалтай тул байнгын анхаарлын төвд байх ёстой. Урт хугацааны уулзалтыг хол газраас ирсэн хоригдогчийн гэр бүлд олгох нь зүйтэй. Хэрвээ гэр бүл нь алс байдаг бол утсаар харилцана.

---

***Анхаарах зүйл:** Хоригдогсодын гадаад орчинтой харилцах харилцаанд анхаарал тавьснаар тухайн хоригдлолын хүн гэсэн нэр төрийг хүндэтгэх, тэдэнд өөртөө итгэх итгэл өгөх, гэр бүл найз нөхдийн харилцааг нь хэвээр хадгалж нийгэмд эргэн ороход нь хялбар байх нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтойгоос гадна хоригдогсод эрхээ хамгаалах боломж, бололцоог нээж өгч тэдний эрхийг баталгаажуулж буй хэрэг юм.*

---

### **Шалгах асуулт**

- Хувийн захидлыг шалгадаг уу?
- Тийм бол шалгалт ямар шалгууртай ба энэ тухай хоригдогсод мэдэх үү?
- Илгээмжийг ямар нөхцөлтэй авах вэ?
- Гэр бүл нь уулзахыг тогтмол зөвшөөрдөг үү?
- Уулзалт ямар хугацаанд үргэлжилдэг вэ?
- Онцгой төрлийн хоригдогсдын эргэлт, уулзалтанд хязгаарлалт бий юу?
- Тийм бол ямар үндэслэлтэй вэ?
- Хоригдогсдын ар гэрийнхнийг хорих, цагдан хорих газрын ажилтнууд ямар байдлаар хүлээж авдаг вэ?
- Ийм уулзалтанд зориулагдсан материаллаг нөхцөл ямар вэ?
- Эргэлтгүй хоригдогсод нийгмийн ямар нэгэн арга хэмжээ авдаг уу?
- Хоригдогсод мэдээллийн хэрэгсэл (сонин хэвлэл, телевиз) ашигладаг уу?
- Аливаа хязгаарлалт бий юу? Мэдээллийн хэрэгсэл ашиглах ямар шалгуур байдаг вэ?

### **Нэмж унших материал**

- “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”
- “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”
- ХЗДХ сайдын 2008 онд 50 тоот тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журам
- Монгол Улсынн Эрүү, Иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн түүхэн хөгжил /1931-2005/, 2005 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл /2008 он/

- Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь гарын авлага, 2005 он, Эмнести Интернэшнл
- “Кино хэлэлцүүлгээр амьдрах чадвар олгож, хандлагыг өөрчлөх нь” 2007 он, Эмнести Интернэшнл

## **МАТЕРИАЛЛАГ НӨХЦӨЛ**

Хорих, цагдан хорих газарт боломжийн нөхцөл бүрдүүлэх нь хоригдогчийн хүний эрх, нэр төрийг хадгалахад чиглэгдсэн зайлшгүй шаардлагатай нөхцөл юм. Амьдрах байр, хүнс, хувийн ариун цэвэр зэрэг нь хоригдогчийн эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах хүчин зүйлүүд билээ.

Хорих, цагдан хорих газар хүнээр дүүрэх, хэт олшрох асуудал илүү ноцтой бөгөөд энэ нь юуны түрүүнд хорих нөхцлийн бусад хүчин зүйлүүдэд сөргөөр нөлөөлж, хорих, цагдан хорих газруудын ерөнхий орчин нөхцлийг доройтуулдаг. Дээрхи ноцтой асуудал тодорхой түвшинд хүрмэгц хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон гутаасан хэрэг болно.

### **Материаллаг нөхцөлд:**

§ Хол хүнс, ундны ус

§ Гэрэлтүүлэг ба агааржуулалт

§ Эрүүл ахуйн нөхцөл

§ Хувийн ариун цэвэр

§ Хувцас, цагаан хэрэглэл

§ Хоригдож буй этгээдийг зохистой байрлуулах

## **ХООЛ ХҮНС, УНДНЫ УС**

1. Шоронгийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдол бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалах хангалттай тэжээллэг, сайн чанарын сайтар бэлтгэж өгсөн хоол ундаар хангах ёстой.

2. Хоригдол бүр хэрэгцээтэй үедээ уух ундааны устай байх ёстой.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 20 дугаар дүрэм)

1. Хорих, цагдан хорих газрын захиргаа эрүүлийг хамгаалах байгууллагаас тогтоосон шаардлагын дагуу сайтар бэлтгэгдсэн, хүнсний норм ба орчин үеийн ариун цэврийн шаардлагад нийцсэн, хоригдогчийн нас, эрүүл мэндийн байдал, хийж буй ажлын байдал, боломжтой бол шүтдэг шашин, ёс, зан заншил зэргийн онцлогийг харгалзсан хүнсээр тогтоосон цагт хоригдогчийг хоол, хүнсээр хангана.

2. Хоригдогч бүр ундны ус хэрэглэх боломжоор хангагдсан байна.

(Европын шоронгийн дүрэм, 25 дахь дүрэм)

Хорих ангийн эмч хоригдогсдын хоол бэлтгэх боловсруулах, олгох явц, хүнсний хадгалалт хамгаалалт, гал зуух, хоолны хэрэгслийн ариун цэвэр, цэвэрлэгээ эрүүл ахуйн шаардлагад өдөр тутам хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хоолны дээжийг заавал авч, шаардлагын дагуу 48-72 цагийн хугацаанд хадгалан, дараа өдөр нь устгана. Хоолноос хордсон гэх тохиолдолд

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

уг хоолны дээжийг шинжилгээнд өгч шийдвэр гаргуулан холбогдох арга хэмжээг авахуулна.

Хэрэв хүүхэд эхчүүд хорих газарт хамт байгаа бол нярай хүүхдүүдийн нэмэлт тэжээлийг эмчийн заавраар олгоно. Насанд хүрээгүй хоригдогчид насанд хүрсэн хоригдогчоос илүү илчлэг, илүү олон нэр төрлийн хоол өгөх, олгох тоог олон байлгавал зохино.

---

**Анхаарах зүйл:** Хоолыг энгийн нөхцөлд байгаа шиг ариун цэврийн шаардлагыг хангаж өгнө. Хоолны амт чанар, хэмжээ, нэр төрөл хоригдогчийн эрүүл мэндийг хангахуйц байна. Түүнчлэн хоригдогсод ял шийтгэл, хийсэн хэргээсээ үл шалтгаалан хэмжээ нормоороо адил хүнсээр хангагдах ёстой. Ундны цэвэр усаар байнга хангагдах, хүссэн үедээ хэрэглэх боломжтой байх ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Хоолны чанар, хэмжээ, нэр төрөл ямар байдаг вэ? Цэсийг хэн тодорхойлдог, хэн хэнээс санал авдаг вэ?
- Хоолны цэсэнд ямар үед өөрчлөлт гардаг вэ?
- Өвчтэй, өндөр настай, ээжтэйгээ байгаа бага насны хүүхдэд тусгай хоол, нэмэлт тэжээл өгдөг үү?
- Хоол өгөх хоорондын зай тохиромжтой юу?
- Цагийн хуваариас бусад цагт хоригдогч хүнс, ус авч болох уу?
- Шашин шүтлэгээс хамаарч хоолны бүтэц өөрчлөгдөх үү?
- Хоригдогсод өөрсдөө хоол хүнсний зүйл авах боломжтой юу?
- Ар гэрийнхэнээсээ хүнсний зүйл ямар хэлбэрээр (илгээмж, эргэлт), хэдий хэмжээгээр авах боломжтой вэ? Хэр зайтай авч болх вэ?
- Хорих, цагдан хорих газрын эмч хоолны норм, хадгалалт эрүүл ахуй, шинжилгээ зэрэгт хяналт тавьдаг уу?
- Хоолыг басамжлах байдалтай (шидэх, цацах) тараах тохиолдол гардаг уу?

### **ГЭРЭЛТҮҮЛЭГ БА АГААРЖУУЛАЛТ**

а. Хоригдогч хэвийн нөхцөлд байгалийн гэрэлд унших, ажиллах боломжтой байхаар том цонхтой байна. Агааржуулалтын тоног төхөөрөмж суурилуулаагүй тохиолдолд цонх нь цэвэр агаар оруулах боломжтой хийгдсэн байна. Үүний зэрэгцээ аюулгүй байдлын шаардлагыг хангасан нөхцөлд цонх нь хэмжээ, байрлал, бүтцээрээ хэвийн цонхонд дээд зэргээр ойртож очсон байх ёстой.

б. Хиймэл гэрэлтүүлэг нь нийтийн хэрэглээний гэрэлтүүлгийн техникийн нормд дүйцэх ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 16 дахь дүрэм)

Хоригдлуудын амьдарч ажиллаж байгаа өрөө тасалгаанд:

а/ Цонх нь байгалийн гэрэлд уншиж, ажиллаж болох хангалттай хэмжээтэй, агааржуулалтын хиймэл системтэй эсэхээс үл хамааран цэвэр агаар орохоор хийгдсэн байвал зохино.

б/ Хиймэл гэрэлтүүлэг нь хоригдлын хараанд аюулгүй, уншиж, ажиллаж болохоор хангалттай байвал зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 11 дүгээр дүрэм)

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хороо хорих, цагдан хорих газрын цонхонд төмөр хаалт, хөндлөвч, хавтан зэргийг бөхөлж хоригдогсдын байранд нэвтрэх байгалийн гэрэл, цэвэр агаарыг боогдуулж байгаатай байнга тааралддаг. Ялангуяа урьдчилан хорих газарт ихэвчлэн ийм байна. Тэнд хоригдогсод нууцаар хэлэлцэх, гэмт үйлдэл хийхээс урьдчилан сэргийлж ийм арга хэмжээ авах нь зүйтэй гэдэгтэй Эрүү шүүлт урьдчилан сэргийлэх Европын Хороо санал нэгтэй байгаа боловч энэ нь тодорхой бүлэг хоригдогсдод хамааралтай асуудал байхад нийтээр хэрэгжүүлэх журам болгосон нь зохисгүй гэж үзэж байна. Тиймээс эрх бүхий байгууллагууд хоригдогч тус бүрийн байдлыг анхааран үзээд тухайн хоригдогчид ийм арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тодорхойлдог байх нь зүйтэй. Цаашилбал, урьдчилан сэргийлэх ийм арга хэмжээ хэдийгээр байх ёстой ч хоригдогчийн байгалийн гэрэл, цэвэр агаарыг боогдуулах ёсгүй юм. Байгалийн гэрэл, цэвэр агаар нь хоригдогчийн амьдрах нөхцлийг хангах суурь үзүүлэлт бөгөөд хоригдогч эдгээрийг ашиглах эрхтэй. Түүгээр ч зогсохгүй эдгээр үзүүлэлт хангалттай байхгүйгээс өвчин, ялангуяа сүрьеэ өвчин халдварлах нөхцлийг бүрдүүлж байна.

Хорих байранд амьдралын зохистой нөхцлийг бүрдүүлэхэд хэтэрхий өндөр үнэ шаардагдах ба зарим улс оронд хангалттай санхүүжилт хийгддэггүйгээс хүндрэл учирдаг гэдэгтэй Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хороо санал нэгтэй байна. Гэвч хоригдогсдын цонхонд бөхөлсөн зүйлсийг авч хаях (тэгээд шаардлагатай газарт нь зохих бүтцийн дагуу урьдчилан сэргийлэх төхөөрөмж байрлуулах) нь нэг их зардал шаардах асуудал биш бөгөөд харин ч энэ асуудалтай холбоотой бүх хүнд ашигтай зүйл юм.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Арваннэгдэх Ерөнхий Илтгэл, зүйл 30)

---

**Анхаарах зүйл:** Гэрэлтүүлэг, агааржуулалт нь эрүүл ахуй болон амьдрах орчны нөхцөл, харагдах байдалд ихээхэн нөлөөтэй зүйл бөгөөд байгалийн гэрэл цэвэр агаар оруулах нөхцлийг хаах ёсгүй.

---

### **Шалгах асуулт**

- Гэрэлтүүлэг нь юм уншихад хангалттай хүрэлцэхүйц үү?
- Хоригдогсод гэрэлтүүлэг болон агааржуулалтаа өөрсдөө тохируулах боломжтой юу?
- Хоригдлын гаргасан ямар нэг алдаа дутагдлаас болж гэрэлтүүлгийг өөрчлөх (хэт бүдэг, хурц болгох), цонхийг удаан хугацаагаар хааж битүүлэх зэрэг байдал гардаг уу?
- Дулааны асуудлыг шийдэх явцад гэрэлтүүлэг болон агааржуулалтад өөрчлөлт гардаг уу?

## **ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛ**

Хорих анги хоригдогсдыг өөрийгөө цэвэр авч явахыг байнга шаардаж, ариун цэврийн хэрэгслээр хангах үүрэгтэй.

Хувийн чөлөөт цагаараа хувцас цагаан хэрэглэлээ угаах, хатаах индүүдэх нөхцөл боломжийг хангах тусгай өрөөг тохижуулж өгнө.

Ариун цэврийн төхөөрөмжүүд нь хоригдол бүр шаардлагатай үедээ, цэвэр, тохиромжтой нөхцөлд өөрийн байгалийн хэрэгцээгээ хангаж болохоор хангалттай байвал зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 12 дугаар дүрэм)

Ариун цэврийн төхөөрөмжүүд ба түүнийг ашиглах боломж нь хоригдогсод шаардлагатай үедээ, цэвэр, тохиромжтой нөхцөлд байгалийн хэрэгцээгээ хангахуйц байх ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 17 дахь дүрэм)

Бие засах шаардлага хангасан төхөөрөмжийг шаардлагатай үедээ чөлөөтэй ашиглах боломж ба тэдгээрийг эрүүл ахуйн стандартад нийцэхээр байлгах нь хүмүүнлэг орчин бүрдүүлэх жинтэй хүчин зүйл юм. Энэ үүднээс Хороо зарим орнуудад хоригдогсод бие махбодийн хэрэгцээгээ хоригдож байгаа өрөөндөө хувинд хангаж, дараа нь түүнийгээ тодорхой цагт гаргаж асгадаг практикийг дэмжихгүй байна. Хоригдож байгаа өрөөнд нь эрүүл ахуйн шаардлага хангахуйц бие засах газартай байх эсхүл шаардлагатай үедээ (шөнийн цагаар ч) бие засах ямар нэгэн боломжоор хангагдах ёстой.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 49)

---

**Анхаарах зүйл:** Хоригдогсод бие махбодийн хэрэгцээгээ (бие засах) тухайн цагт нь сааталгүйгээр, цагийн хуваарьт баригдалгүйгээр хангах. Бие засах газар нь амьдрах байрнаас тусдаа байгаа нөхцөлд сааталгүй ашиглах боломжтой байх нь чухал. Захиргааны зүгээс бие засах газрын техникийн үйлчилгээг тогтмол хийдэг байх ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Хоригдогсдын бие засах газар ба угаалтуур нийт хоригдогчид хангалттай хүрэлцдэг үү?
- Бие засах газар амьдрах орчноос тусдаа байдаг бол
- Ямар нэг цагийн хуваарь горим бий юу?
- Хэн нэгнээс зөвшөөрөл авах ёстой юу?
- Бусдыгаа тодорхой хугацаанд хүлээх шаардлага гардаг уу?
- Амьдрах байрыг шөнө түгжсэн хойно хоригдогсод яаж бие засдаг вэ?
- Хянагчийг дуудах уу?
- Таглаатай сав ашиглах уу?
- Таглаатай сав ашигладаг бол хүн тус бүрт эсвэл хэсэг бүлгээрээ дундаа ашигладаг уу?



- Бохиороо хэрхэн асгаж, цэвэрлэдэг вэ?
- Таглаатай хувин саваа өөр бусад зориулалтаар ялангуяа хүнсний зүйл агуулахаас ангид байлгаж чаддаг уу?
- Тодорхой хугацаагаар үргэлжлэх зохион байгуулалттай арга хэмжээний (соёл, спорт, сургалт хүмүүжлийн ажил) үед бие засахыг хориглодог уу?

### **ХУВИЙН АРИУН ЦЭВЭР**

Усанд орох төхөөрөмж, шүршүүрийн тоо нь хоригдол бүр тухайн цаг агаарын нөхцөлд тохирох халуун усанд жил, улирал, газар зүйн байрлал нь ариун цэврийн ерөнхий шаардлагад нийцэх, усанд орж болохоор өөрөөр хэлбэл ердийн цаг агаарын нөхцөлд байна. Ядахдаа 7 хоногт 1 удаа халуун усанд орох боломжтой байх ёстой.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 13 дугаар дүрэм)

Усанд орох онгоц ба шүршүүрийн тоо хангалттай байх ёстой. Хоригдогч бүр цаг уурын байдалд нийцсэн дулаан орчинд, тухайн орон нутгийн байдал болон тухайн улирлын байдлаас шалтгаалан эрүүл ахуйн хэрэгцээ шаардлагын дагуу усанд орох ёстой. Ямар ч тохиолдолд 7 хоногт нэгээс доошгүй удаа усанд орох ёстой. Боломжтой газар бүрд хоригдогч бүр боломжтой цагт усанд орох боломжтой байх ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 18 дахь дүрэм)

Үүнээс гадна хоригдогсод усанд орох газарт нэвтрэх боломжтой байх ёстой. Түүнчлэн хорих өрөөнд нь ус дамжуулагч байрлуулбал бүр зохистой.

(Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 49)

Эмэгтэйчүүдийн ариун цэврийн онцгой хэрэгцээг холбогдох ёсоор шийдвэрлэх нь зүйтэй. Бие засах газар ба угаалгын өрөөг хориг саадгүй ашиглах, цус нэвтэрсэн материалыг айх аюулгүй хаях, түүнчлэн хувийн ариун цэврийн хэрэгслээр хангагдах зэрэг нь онцгой чухал асуудал юм. Энэ үндсэн хэрэгцээг хангахгүй байвал үүнийг хүний нэр төрийг гутаан доромжилсон харьцаа гэж үзнэ.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 31)

---

**Анхаарах зүйл:** Хувийн ариун цэврийг сахихаас эрүүл мэндийн байдал шалтгаална. Хорих, цагдан хорих газруудын зүгээс хоригдогсдыг хувийн ариун цэврээ сахих хэрэгслээр хангах, ариун цэврийг сахиж, байгаа газраа цэвэрхэн суух зэргийг ажилтнуудын зүгээс анхааран шаардах ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Хорих, цагдан хорих газрын зүгээс хоригдогсодыг ариун цэврийн хэрэгслээр хангадаг уу? Хэр зэрэг тогтмол вэ? Дараагийн удаа тавьж өгтөл хүрэлцдэг үү?
- Эргэлт уулзалт, илгээмжээр ар гэрийнхэнээсээ ариун цэврийн хэрэгслэл авдаг уу? Ямар нэг нөхцөл шаардлагагүйгээр чөлөөтэй оруулдаг уу?
- Хоригдогсод байнга шүршүүрт орох боломжтой юу?
- Хэрвээ боломжгүй бол ямар хугацаанд ордог вэ?
- Ажил хийдэг, хийдэггүй хүмүүсийн усанд орох нь ялгаатай юу?
- Ажлын онцгой нөхцлөөс (тоостой орчинд ажилласан, нүүрс буулгах, мал мах янзлах гэх мэт) шалтгаалан хуваариас гадуур шүршүүрт орох боломжтой юу?
- Эмэгтэйчүүдийн сарын тэмдэг үзэгдэх үед ариун цэврийн хэрэгслээр хангадаг уу?
- Шүршүүрт нэг удаад хэдэн хүн зэрэг орох хүчин чадалтай вэ?
- Шүршүүрт орох үед хоригдлууд өөрсдөө дараалал тогтоож хэн нэгнийг удаан хүлээлгэх байдал гардаг уу?
- Зөөврийн усаар хангагддаг нөхцөлд усны хүрэлцээнээс шалтгаалан хуваарьт өдрөө бүх хоригдогсод шүршүүрт орж амжихгүй тохиолдол байдаг уу? Ийм үед нөхөж оруулах арга хэмжээг хэрхэн зохиодог вэ?

### **ХУВЦАС, ЦАГААН ХЭРЭГЛЭЛ**

1. Энгийн хувцас өмсөх эрхгүй хоригдлуудад тухайн цаг агаарт тохирсон, эрүүл мэндээ хэвийн байлгах боломжтой иж бүрэн хувцас тавьж олгох нь зүйтэй. Энэ хувцас нь гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй.

2. Хувцас нь цэвэр, бүрэн бүтэн байх ёстой. Ариун цэврийн шаардлагыг хангахуйцаар угаасан дотуур хувцас тавьж олгож байвал зохино.

3. Хоригдол эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хорих газраас гарч явах онцгой тохиолдолд түүнд өөрийнхөө хувцсыг, эсвэл нүдэнд өртөхөөргүй бусад хувцас өмсөхийг зөвшөөрөх нь зүйтэй.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 17 дугаар дүрэм)

Хэрэв хоригдлууд энгийн хувцас өмсөхийг зөвшөөрдөг бол хоригдох үед хувцас нь цэвэр, өмсөхөд тохиромжтой байх арга хэмжээ авбал зохино.

(Европын шоронгийн дүрэм, 22 дахь дүрэм)

1. Өөрийнхөө хувцсыг өмсөх эрхгүй хоригдол тухайн газар нутгийн цаг уурын байдалд тохирсон, тэдний эрүүл мэндийг хамгаалахуйц хувцсаар хангагдах ёстой. Энэ хувцас нь хэрхэвч гутаан доромжилсон, нэр төрийг нь унагаасан байж болохгүй.

2. Бүх хувцас нь цэвэр, бүрэн бүтэн байх ёстой. Дотуур хувцсыг ариун цэврийн шаардлагын дагуу тогтмол сольж, угааж байх ёстой.

3. Хорих, цагдан хорих газраас гадуур явах зөвшөөрөл авсан тохиолдолд хоригдогч өөрийнхөө хувцсыг өмсөх, эсвэл нүдэнд өртөхөөргүй өөр хувцас өмсөхийг зөвшөөрөх хэрэгтэй.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 18 дугаар дүрэм)

Хоригдогч бүр тусдаа ор, цэвэр, бүрэн бүтэн цагаан хэрэгслээр хангагдах ёстой бөгөөд тэдгээрийг шаардлага гарсан тохиолдол бүрд солих ёстой.  
(Европын шоронгийн дүрэм, 24 дахь дүрэм)

---

**Анхаарах зүйл:** Хоригдогч бүр унтах ор, цагаан хэрэгслээр хангагдах бөгөөд тэдгээр нь цэвэр, хэрэгцээ хангахуйц байх ёстой. Цагаан хэрэглэлийг 15 хоногт нэгээс доошгүй удаа сольж цэвэрлэх шаардлагатай. Хорих, цагдан хорих газраас олгосон хувцас, цагаан хэрэглэл нь тухайн хоригдогчийн хувийн өмчид тооцогдох ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Цагаан хэрэглэл, дотуур хувцасаа хаанаас авдаг вэ? Ялангуяа эргэлт уулзалтгүй хүмүүс мөн ээлжийнх байгаа эсэх, ариун цэврийн болон эрүү ахуйн шаардлага хангаж буй эсэх.
- Ангиас олгодог цагаан хэрэглэлийг яаж ариутгасан байдаг вэ?
- Цагаан хэрэглэлийг тогтмол сольдог уу?
- Хоригдогсод өөрсдөө хувцасаа угаадаг уу?
- Дотуур хувцасаа угааж ил задгай өлгөсөн гэх зэмлэл авдаг уу?
- Нэгдсэн бус (ар гэрээсээ авсан) цагаан хэрэглэлийн хэлбэр хэмжээ, өнгө зураглал зэргээс үл шалтгаалан дарамт шахалтгүйгээр хэрэглэх боломжтой юу?

### **Нэмж унших материал**

- Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны 1999 оны 1-дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай 10 дахь Ерөнхий илтгэл,
- Европын Зөвлөлийн орнуудын Сайд нарын хорооноос 1987 оны 2 дугаар сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм,
- Бээжингийн дүрмүүд
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай 2 дахь Ерөнхий илтгэл,
- Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэлийн тухай Монгол Улсын хууль
- ХЗДХ-ийн сайдын 2008 оны 50 тоот тушаал
- Монгол Улсын Эрүү, Иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн түүхэн хөгжил /1931-2005/, 2005 он.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл /2008 он/
- Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь гарын авлага, 2005 он. Эмнести Интернэшнл

## **БОЛОВСРОЛ, СУРГАЛТ**

Хорих газар бүрд хоригдогсдын ядаж наад захын эрх ашиг, сонирхлоо хангахад чиглэгдсэн сургалтын олон талт хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ. Сургалтыг хорих тогтолцооны нэг үндсэн үйл ажиллагаа гэж үзэх бөгөөд бүх хоригдогч боловсрол эзэмших боломжоор хангагдах ёстой. Насанд хүрээгүй хоригдлыг ерөнхий боловсролын сургалтанд бүрэн хамааруулж, бусад хоригдлыг бие дааж, мэдлэгээ дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлнэ. Жирийн дэглэмд ял эдлэж байгаа хоригдол боловсролоо дээшлүүлэхийг хүсвэл хорих ангийн захиргаанаас их дээд сургууль, коллежид ичнээгээр суралцуулах боломжтой байх ёстой бөгөөд үүнийг хууль зүйн дагуу зохион байгуулна.

Саатуулагдсан болон хоригдсон этгээд саатуулах буюу хорих газрын дэг, аюулгүй байдлын журмыг сахих нөхцөлд улсын эх үүсвэрээс бол сурах бичиг, уран зохиолын болон мэдээллийн материалыг авч хэрэглэх эрхтэй.

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 28 дугаар зарчим)

1. Хоригдлыг шинээр боловсрол (жишээ нь шашны хүмүүжил) эзэмших нөхцөл бололцоогоор хангана. Бичиг үсэггүй буюу залуу хоригдлуудыг сургалтад заавал хамруулах ба үүнд хорих газар онцгой анхаарал тавих ёстой.

2. Хоригдлыг тухайн орны боловсролын системийн дагуу сургана. Энэ нь хорих газраас суллагдсан хоригдлын цаашид суралцахад хүндрэл учруулахгүй байхад чиглэнэ.

3. Албан боловсрол эзэмших насанд хүрээгүй хүн бүр эрэлт хэрэгцээ, авьяас чадвартаа тохирсон нийгмийн амьдралд буцаж ороход нь бэлтгэх зорилготой боловсрол эзэмших эрхтэй. Суллагдсаныхаа дараа үргэлжлүүлэн боловсрол эзэмшихэд нь ямар нэгэн хүндрэл гарахааргүй хөтөлбөрийн дагуу олгох ёстой.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 77 дугаар дүрэм)

Бүх хорих газарт хоригдлын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс соёл амралтын үйл ажиллагааг бололцоогоор явуулах нөхцөлөөр хангавал зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 78, 82 дугаар дүрэм)

Хорих газар бүр хоригдогчийн наад захын эрх ашиг, сонирхлоо хангахад чиглэгдсэн сургалтын олон талт хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн зорилго нь хоригдогсодыг нийгэмшүүлэх ажлыг улам сайжруулах, хоригдогсдыг сэтгэлийн тэнхээтэй байлгах, эргэн тойрны хүмүүстэйгээ сайн харилцах, өөрийгөө хүндэтгэх харилцааг дээшлүүлэхэд оршино.

(Европын шоронгийн дүрэм, 77 дахь дүрэм)

Сургалтыг хорих тогтолцооны нэг үндсэн үйл ажиллагаа гэж үзэх бөгөөд сургалт нь бусад хөдөлмөрийн нэгэн адил эрх хэмжээнд тавигдаж, ажлын цагаар явагддаг бол төлбөртэй байна. Сургалт нь засан хүмүүжүүлэх батлагдсан хөтөлбөрт тооцогдоно.

(Европын шоронгийн дүрэм, 78-82 дахь дүрэм)

Бүх хоригдогсод боловсрол эзэмших боломжоор хангагдах ёстой. Боловсролын хөтөлбөрт ерөнхий боловсролын хичээл, мэргэжлийн сургалт, соёл олон түмний ажил, уран бүтээлийн сургалт, биеийн тамир, спортын сургалт, нийгмийн сургалт, номын сангийн хэрэгслүүд зэрэг багтана.

(Шоронд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай Зөвлөмж, зүйл 1)

Арга хэмжээний сайн хөтөлбөр нь (ажил, боловсрол, спорт г.м) хоригдогсдын сэтгэл санааны байдалд шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Энэ нь сэжигтэн, яллагдагчийн алинд ч хамаатай. Хоригдогч олон хонолгүй шилждэг хорих газарт үйл ажиллагаа зохион байгуулах нь амаргүй асуудал. Гэхдээ хоригдогсод хэдэн долоо хоногоор, хэдэн сараар хэдийгээр материаллаг нөхцлөөр сайн хангагдсан ч өрөөндөө юу ч хийхгүй түгжээтэй байж болохгүй. Тиймээс цагдан хорих байранд хоригдож байгаа сэжигтнүүд өдрийн ихэнх хэсгийг 8 цаг буюу түүнээс ихээр хорих өрөөнөөсөө гадуур ямар нэг төрлийн ашигтай үйл ажиллагаа эрхэлж өнгөрөөх нь зүйтэй

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 47)

---

**Анхаарах зүйл:** Хоригдлыг нийгэмшүүлэх, цаашид хөдөлмөр эрхлэхэд боловсрол зайлшгүй чухал бөгөөд хувь хүний хэрэгцээ шаардлагад нийцсэн байх ёстой. Хоригдогсод боловсрол олгох үйл ажиллагааг жишиг хэм хэмжээний дагуу явуулснаар хурдан нийгэмших, өөртөө итгэлтэй болох, өөрийн үнэ цэнийг ухаарах, сайжрах, үзэл хандлага, буруу дадлаа өөрчлөх боломжийг хоригдогсод олгодгоороо ач холбогдолтой юм.

---

### **Шалгах асуулт**

- Боловсролын ямар хэлбэрийг санал болгодог вэ?
- Боловсролын хөтөлбөрийг хорих, цагдан хорих газрын захиргаанаас хязгаарладаг уу?
- Сургалтын хөтөлбөр нь хоригдогсдын хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийг тусгасан, нийгэмшүүлэх зорилготой нийцдэг үү?
- Мэргэжлийн хурдан нийгэмших, өөртөө итгэлтэй болох, өөрийн үнэ цэнийг ухаарах, сайжрах, үзэл хандлага, буруу дадлаа өөрчлөх боломжийг хоригдогсод олгодгоороо ач холбогдолтой юм?
- Өөрсдийн хүсэлтээр боловсрол олгох үйл явцад хамрагдаж болох уу?
- Хуулийн заалтын дагуу хоригдогч зардалаа гаргаад тусгай сургалт, зөвлөгөө авах боломжийг гаргаж өгдөг үү?
- Хоригдогсод номын санг ашиглахад ямар нэг нөхцөл байдаг уу?
- Номын санд байгаа номнууд хоригдогсдын ярьдаг хэл дээр байж чаддаг уу?
- Номын сангийн номын хүрэлцээ, баяжилтад хоригдогсдын саналыг харгалзан үздэг үү?

### **Чөлөөт цаг**

Хоригдогсдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг зохистой түвшинд байлгахад чиглэгдсэн биеийн хүчний болон спортоор хичээллэх, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх зэрэг зохион байгуулалтай үйл ажиллагаа чухал.

(Европын шоронгийн дүрэм, 83 дахь дүрэм)

Биеийн тамирын боловсрол олгох, спортоор хичээллэх, түүнчлэн чөлөөт цагийг өнгөрүүлэх бусад арга хэмжээг хорих дэглэмийн зөвшөөрөгдсөн хүрээнд зохион байгуулах ёстой. Ийм хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай талбай, тоног төхөөрөмжөөр хангах ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 84 дэх дүрэм ,түүнчлэн 85 дахь дүрэм)

---

***Анхаарах зүйл:** Хоригдож байгаа этгээд нийгмийн амьдралд байсантай адил чөлөөт цагтаа ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх, жишээ нь спортоор хичээллэх зэрэг боломжоор хангагдах ёстой.*

---

### **Шалгах асуулт**

- Хоригдогсод ямар төрлийн спортоор хичээллэх боломжтой вэ?
- Тэд өөр ямар төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжтой вэ? Энэ нь байнга байдаг уу?
- Аливаа хязгаарлалт бий юу? Тийм бол ямар шалгууртай вэ?
- Мэдээллийн хэрэгсэл (сонин хэвлэл, телевиз) ашиглах боломжтой юу? Энэ нь хуваарьт цагийг дагуу байх уу? Бусад хоригдогсодоос үл хамааран үүнийгээ шийдэх боломжтой юу?
- Хорих, цагдан хорих газрын захиргаа сонин, сэтгүүл, бусад тогтмол хэвлэлийг үнэгүй ашиглуулдаг уу?
- Кино, концерт үзэх зэргээр соёлын арга хэмжээ зохиогддог уу?
- Амралтын өрөө байдаг уу? Чөлөөт цагаа ямар төрлийн үйл ажиллагаа эрхэлж өнгөрүүлдэг вэ?

### **Шашин шүтлэг**

1. Хорих газарт аль нэг шашинг шүтдэг хангалттай тооны хоригдол байвал тухайн шашны мэргэжлийн ламыг томилох буюу хорих газарт зохих зан үйл явуулах зөвшөөрөл олговол зохино. Хэрэв ийм хоригдол их олон бөгөөд боломжтой бол ламыг байнга ажиллуулахаар томилно.

2. Томилогдсон буюу зөвшөөрөгдсөн мэргэжлийн лам нь шашны зан үйлийг тогтоосон цагт байнга явуулах, тухайн шашныг шүтдэг хоригдолтой ганцаарчлан уулзаж, шашны сэдвээр ярилцах боломжтой байх ёстой.

3. Аль ч шашны мэргэжлийн ламтай хоригдол уулзах боломжийг хязгаарлаж болохгүй. Нөгөө талаас хоригдол ламтай уулзахыг эсэргүүцвэл түүний хүсэлтэд бүрэн хүндэтгэлтэй хандах ёстой.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 41 дүгээр дүрэм)

Хоригдол бүр хэрэгжүүлж болох хүрээнд шашны зан үйл явуулахад оролцож, шашны ном зохиолтой байж өөрийн хэрэгцээгээ хангах боломжтой байх ёстой.

Хоригдол бүрд боломжийн хирээр өөрийн шашин шүтлэг, оюун санааны болон ёс суртахууны хэрэгцээгээ хангах, үүний тулд хорих байранд зохион байгуулагдах зан үйл, хурал цуглаанд оролцох, шаардлагатай ном, хэвлэлтэй байх зөвшөөрөл олгох ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 46 47 дахь дүрэм)

*Анхаарах зүйл: Шашин шүтэх, эс шүтэх эрх нь хүний үндсэн суурь эрхүүдийн нэг бөгөөд ямар нэг үүрэг нөхцөлгүйгээр эдлэх боломжтой байх ёстой.*

### **Шалгах асуулт**

- Өөрийн шүтдэг шашны төлөөлөгчтэй уулзах, үйлчилгээ авах боломж хэр байдаг вэ?
- Уламжлалт шашнаас бусад шашинг хэн нэгний шахалт шаардлагаар шүтэх болдог уу?
- Шашны цугларалтад орсоноос, эсвэл шүтсэнээс болж ямар нэг дарамт шахалт ирдэг үү?
- Гадаадын хоригдол бол өөрийн шашны зан үйлийг гүйцэтгэхэд ямар нэг бэрхшээл тулгардаг уу?
- Шашин шүтдэг хоригдогсдын тоо ямар байвал тухайн шашны төлөөлөгчтэй уулзах зөвшөөрөл олгодог вэ?
- Тухайн хорих, цагдан хорих газарт ямар шашны байгууллага, төлөөлөгчид ирдэг вэ? Тэдгээр нь хоригдогсдын шүтдэг шашин мөн үү?
- Шашны байгууллага, төлөөлөгчид хорих, цагдан хорих газарт ажиллахын тулд ямар нөхцөл болзолыг хангаж зөвшөөрөл авдаг вэ?

### **Нэмж унших материал**

- Европын Зөвлөлийн орнуудын гишүүн орнуудын Сайд нарын хорооноос 1987 оны 2-дугаар сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм,
- Европын Зөвлөлийн орнуудын гишүүн орнуудын Сайд нарын хорооноос 1989 оны 10 -дугаар сарын 13-нд батлагдсан Шоронд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай Зөвлөмж, НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаар анхны их хурал дээр 1955 онд баталсан хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”
- “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”
- Бээжингийн дүрмүүд
- НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарчмууд
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрх, эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, УБ хот, 2006 он, 128 дахь тал

## **ДЭГЛЭМ БА ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**

Хорих байрын дэглэм гэдэгт /ялын төрлөөс жишээ нь жир, чанга, насанд хүрээгүй гэх зэргээс гадна гадаад ертөнцтэй холбогдох харилцаа нэгэн адил хамаарна. Хоригдогсодыг нийгэмшүүлэхэд тэднийг гадаад ертөнцтэй холбох буюу гэр бүл, төрөл төрөгсөдтэй нь харилцаатай байлгах явдал чухал ач холбогдолтой.

Хоригдогсдын хувьд амьдрах байрнаасаа гадуур өнгөрүүлж байгаа цаг хугацаа, жишээ нь ажил, сургалт, түүнчлэн чөлөөт цагийг зохион байгуулалттай өнгөрүүлэх зэрэг нь чухал ач холбогдолтой байдаг.

Хорих, цагдан хорих газруудын дотоод журмыг яг таг биелүүлэх ёстой боловч сахилга батыг хангахдаа тодорхой журмаар, зөв аргаар хэрэгжүүлэх ёстой. Сахилгын арга хэмжээг авахад ч тодорхой баталгаагаар хангах ёстой. Энэ нь хоригдогсодоос хорих, цагдан хорих газрын дотоодод ч, гадаад орчны холбогдох албан байгууллагуудад ч чөлөөтэй гомдол гаргах, гомдол гаргаснаасаа болж аливаа аюулд өртөхгүй байх нөхцлөөр хангагдах явдал юм. Шалгалтын хараат бус арга хэрэгслүүд нь хоригдож байгаа этгээдийн хүний эрхийг хангах нөхцөлд чухал нөлөө үзүүлнэ.

Өөр бусад арга хэмжээнүүд ч мөн адил хорих, цагдан хорих газарт дураараа дургих замбараагүй байдал гаргахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Эдгээр арга хэмжээнүүд нь хоригдогсодыг ангиллаар нь ялган зааглах, холбогдох бүртгэлүүдийг хөтлөх, байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зэрэг болно.

### **Дэглэм ба хамгаалалтын арга хэмжээ:**

- § Хоригдож буй этгээдийн ангилал
- § Хоригдлыг байрлуулах
- § Хамгаалалтын арга хэмжээ
- § Хяналт шалгалт
- § Сахилгын арга хэмжээ
- § Ганцаарчилан хорих
- § Гомдол гаргах журам

### **ХОРИГДОЖ БАЙГАА ЭТГЭЭДИЙН АНГИЛАЛ**

- 1/ Дараах зүйлийг зохих ёсоор тэмдэглэлд бичнэ.
  - а/ Баривчилсан шалтгаан
  - б/ Тухайн этгээдийг баривчилсан цаг, түүнийг саатуулах газарт хүргэсэн цаг, түүнчлэн тэр анх удаа шүүхэд буюу бусад байгууллагад хүргэгдсэн цаг
  - в/ Хууль хэрэгжүүлэх байгууллагын зохих албан тушаалтнуудын овог нэр
  - г/ Хорих газартай холбогдолтой тодорхой мэдээлэл

2/ Хуульд заасан хэлбэрээр бичигдсэн тэмдэглэлийг саатуулагдсан этгээдэд, өмгөөлөгчтэй бол түүнд танилцуулна.

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 12 дугаар зарчим)



1.Хорих газар бүрт дугаарласан хуудастай хавтасласан дэвтрийн хэлбэртэй бүртгэл байвал зохих бөгөөд түүнд хоригдогч бүрийн талаар дараахи зүйлийг бичих ёстой.

- а/ Хувийн байдалтай нь холбоотой мэдээлэл
- б/ Хоригдсон шалтгаан ба хорих шийдвэр гаргасан байгууллага
- в/ Хорих газарт ирсэн болон гарсан өдөр, цаг

2.Хэнийг ч хүчин төгөлдөр хорих тогтоолгүйгээр хорих, цагдан хорих газарт хүлээн авах ёсгүй бөгөөд тогтоолын дэлгэрэнгүй утгыг бүртгэлд урьдчилан тусгана.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 7 дугаар дүрэм)

1. Хэнийг ч хуулийн хүчин төгөлдөр болсон зохих баримт бичиггүйгээр хорих, цагдан хорих газарт хүлээн авч хорихыг хориглоно.

2. Хоригдогчийг хүлээн авсан ба хорьсон тухай тэр даруй бүртгэнэ.  
(Европын шоронгийн дүрэм, 7 дахь дүрэм)

Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд яллагдагчийг хоригдлуудаас тусад нь, яллагдаагүй хүний эрхэд нийцсэн тусгай дэглэмд байлгана.

б/ Насанд хүрээгүй яллагдагчийг насанд хүрэгсдээс тусад нь байлгаж, шүүхийн шийдвэр гаргуулахаар шүүхэд яаралтай хүргэнэ

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10.2 дугаар зүйл)

Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй хэрхэн харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад эсхүл нэг хорих газрын өөр өөр хэсэгт байлгана. Ингэснээр:

а/ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг боломжийн хэрээр тусдаа хорих газруудад байлгана.

б/ Хэрэв эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг хорих газарт байгаа бол эмэгтэйчүүдийг тусдаа өрөө тасалгаанд байрлуулбал зохино.

в/ Шүүхээр ял шийтгүүлээгүй хүмүүсийг хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс тусад нь байлгана.

г/ Өөрийн үүргээ биелүүлээгүй буюу иргэний бусад хэрэгт холбогдон хоригдож байгаа хүмүүсийг эрүүгийн гэмт хэрэг үйлдэж хоригдож байгаа хүмүүсээс тусад нь байлгавал зохино.

д/ Эрх зүйн зөрчил үйлдсэн бага насны хүмүүсийг насанд хүрэгчдээс тусад нь хорино.

(Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 8 дугаар дүрэм (түүнчлэн 85-ыг үз)

1.Хоригдогсодыг хорих, цагдан хорих газруудад хуваарилахдаа, эсхүл түүний хоригдох дэглэмийг сонгохдоо шүүхээр буюу хуулиар тогтоосон эрх зүйн байдал, (сэжигтэн, яллагдагч, анхны ба давтан гэмт хэрэгтэн, богино хугацааны ба урт хугацааны ял авсан) засан хүмүүжүүлэхтэй холбоотой онцгой шаардлагууд,

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

биеийн эрүүл мэндийн байдал, нас, хүйс зэргийг анхаарч үзнэ.

2.Эрэгтэй, эмэгтэй хүмүүс зохион байгуулалттай гэмт хэрэг хамтран үйлдэж, нэг хөтөлбөрөөр засан хүмүүжүүлэгдэх байсан ч тусад нь хорино.

3.Хоригдогсод өөрсдөө зөвшөөрсөн болон зохион байгуулалттай үйл ажиллагаанд хамтран оролцож байгаагаас бусад тохиолдолд сэжигтэн, яллагдагчийг тусад нь хорино.

4.Залуу хүмүүсийг, тэдэнд үзүүлэх муу нөлөөнөөс хамгаалсан, насны байдалд тохирсон нөхцөлд хорино.

(Европын шоронгийн дүрэм, 11 дэх дүрэм (түүнчлэн 12 ба 13-ыг үз):

Хоригдогч эмэгтэйчүүдийг тухайн хорих, цагдан хорих газарт хоригдож байгаа эрэгтэйчүүдээс тусгаарлан хорих нь зарчмын чухал асуудал юм. Гэхдээ зарим улс оронд хоригдогч гэр бүлийн гишүүдийг хамтад нь хорих буюу тодорхой түвшинд холбоотой байх нөхцөл бүрдүүлэх зорилгоор эрэгтэй, эмэгтэй хоригдогсодыг хамт хорих явдал байдаг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо дэвшилттэй ийм хэлбэрийг зөвхөн тухайн хоригдогсод өөрсдөө зөвшөөрсөн болон тэднийг нарийвчлан сонгосон тохиолдолд, түүнчлэн зохих ёсны хяналттай нөхцөлд хөхүүлэн дэмжиж байна.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 24)

### **Шалгах асуулт**

- Шинээр ирсэн хоригдлыг хүлээн авахад ямар тэмдэглэл хөтөлдөг вэ?
- Суллагдагсдын болон шилжүүлгийн бүртгэлийг хэрхэн хөтөлдөг вэ? Ямар мэдээлэл хорих ангид үлддэг вэ?
- Тухайн ангид ирэхэд тусгайлсан бүртгэлийн дэвтэр, хувийн хэрэг нээдэг үү?
- Бүртгэлийн дэвтэр хувийн хэрэгт юу юуг тэмдэглэдэг вэ?
- Бүртгэл хувийн хэрэгт нэмэгдэж тэмдэглэгдэж байгаа зүйлийг хоригдолд мэдээлдэг үү?
- Шинээр ирсэн хоригдлыг хүлээн авахад ямар тэмдэглэл хөтөлдөг вэ?
- Суллагдагсдын болон шилжүүлгийн бүртгэлийг хэрхэн хөтөлдөг вэ? Ямар мэдээлэл хорих ангид үлддэг вэ?
- Тухайн ангид ирэхэд тусгайлсан бүртгэлийн дэвтэр, хувийн хэрэг нээдэг үү?
- Бүртгэлийн дэвтэр хувийн хэрэгт юу юуг тэмдэглэдэг вэ?
- Бүртгэл хувийн хэрэгт нэмэгдэж тэмдэглэгдэж байгаа зүйлийг хоригдолд мэдээлдэг үү?

### **ХОРИГДОЖ БҮЙ ЭТГЭЭДИЙГ ЗОХИСТОЙ БАЙРШУУЛАХ**

Хорих, цагдан хорих газарт хүнээр дүүрэх хэт олшрох асуудал илүү ноцтой бөгөөд энэ нь юуны түрүүнд хорих нөхцлийн бусад хүчин зүйлүүдэд сөргөөр нөлөөлж, хорих, цагдан хорих газруудын ерөнхий орчин нөхцлийг доройтуулна. Дээрхи ноцтой асуудал тодорхой төвшинд хүрмэгц тэнд хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон гутаасан хэрэг болно.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 46)

Төр өөрийн олон иргэнээ шоронд хорьсоор байгааг гэмт хэргийн түвшин итгэлтэй баталж чадахгүй байна. Энэ нь хууль хяналтын байгууллага, шүүх засаглалын нийтлэг хандлага хариуцлагагүй байгаатай зарим талаараа холбоотой

Ийм байдалд дахин шинэ шорон барих ажилд их хэмжээний мөнгө зарцуулах нь асуудлыг шийдвэрлэхгүй. Үүний оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон шүүхийн мөрдөн байцаалт ба ял оноох шатанд хорих асуудал, түүнчлэн ял оноох боломжийн өөр төрлийн хэлбэр байж болох талаар нягталж үзэх нь чухал байна. Чухам ийм хандлага хэрэглэхийг Сайд нарын шорон дүүргэлт ба шоронгийн хүн ам өсөлтийн асуудал эрэлсэн Хорооны °R(99)22 тоот Зөвлөмжид уриалсан. Эрүү шүүлтийн эсрэг Европын Хороо энэ чухал баримт бичигт дурдагдсан зарчмуудыг гишүүн орнууд амьдралд хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна. Эдгээр Зөвлөмжийн хэрэгжилтэнд Европын Зөвлөл чанд хяналт тавих нь зүйтэй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Арваннэгдүгээр Ерөнхий Илтгэл, зүйл 28)

1. Хоригдогсдыг шөнө бусадтай нь хамт байлгах шаардлага гараагүй тохиолдолд ихэвчлэн өрөөнүүдэд хуваарилан байрлуулна.

2. Нийтээр нь хамт байлгах тохиолдолд хоригдогсод энэ нөхцөлдөө бусадтайгаа харилцаж болно. Шөнийн цагаар тухайн хорих байрын тогтоосон журмаар хяналтад байна.

(Европын шоронгийн дүрэм, 14 дэх дүрэм)

1. Хоригдлууд гянданд буюу тасалгаандаа хонодог бол хүн бүр тусдаа өөрийн гтасалгаатай байх ёстой. Хэрэв түр хугацаанд шорон дүүрсэн онцгой шалтгаанаар л биш бол шоронгийн төв захиргаа энэ журмыг хэрэглэхээс татгалзахад хүрч нэг гяндан буюу тасалгаанд хоёр хоригдлыг байлгах нь зохимжгүй.

2. Нийтийн гяндантай газар хоригдлуудыг тэд тийм нөхцөлд хамтран амьдрах чадвартай гэдгийг магадалж онцгой нямбай сонговол зохино. Шөнийн цагт хорих газрын онцлогт тохирсон байнгын хяналт тавих хэрэгтэй.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 9 дүгээр дүрэм)

Төв ба Дорнод Европын орнуудад хоригдогсдын амьдрах байр нь их том багтаамжтай, хоригдогсдын өдөр тутам хэрэглэдэг бүх зүйл, амрах байр, амьдралын бүс, ариун цэврийн бүх тоног төхөөрөмжийг бүхэлд нь багтаасан байдаг. Эрүү шүүлтийн эсрэг Европын Хороо хаалттай шоронгуудыг ийм зарчмаар төлөвлөхийн эсрэг байгаа ба ялангуяа хоригдогсод эрүүл бус нөхцөлд байна. Зарим улс орнуудад соёлын болон бусад төрөл бүрийн хүчин зүйлсийн нөлөөгөөр ганцаарчлан бус олноор нь хорихыг илүүд үздэг болсон нь эргэлзээгүй. Гэхдээ үүнийг зөвтгөх шалтгаан байхгүй.

Олноор нь хорих өрөөнд хоригдогсод өдөр тутмын амьдралдаа ганцаараа

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

байх боломжийг олгохгүй. Үүнээс гадна айлгах, хүчирхийлэх эрсдэл өндөртэй. Ийм зохион байгуулалттай байранд эрх зүйн зөрчил гарах, гэмт хэргийн бүлэглэл үүсэх орчин бий болж хөгжихөд түлхэц өгнө. Нөгөө талаас албан хаагчдын зүгээс зохих ёсны хяналт тавих явдлыг хүндрүүлж, эсхүл ийм хяналт тавих боломжийг бүрмөсөн үгүй болгох, тэрчлэн гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр бүх хоригдогсодыг хамарсан үймээн сандраан болохоос урьдчилан сэргийлэх аргагүй байдалд оруулна. Энэ бүх асуудал хоригдогсдын тоо байж болох хэмжээнээс давсан тохиолдолд улам хүчтэй болж, түүгээр ч зогсохгүй угаалтуур, бие засах байранд нэмэлт ачаалал үүсч, хэтэрхий олон хүнд агааржуулалт хангалтгүй болж нөхцлийг улам дордуулна.

Эрүүдэн шүүхийн эсрэг Европын Хороо олон хүний багтаамжтай хорих өрөөнөөс татгалзаж, цөөн хүнтэй жижиг байранд байлгахдаа хоригдогсдын зорилготой, ашигтай үйл ажиллагаа эрхлүүлэх замаар өдрийн ихэнх цагийг гадуур байлгах нь зүйтэй гэдгийг цохон тэмдэглэж байна.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Арваннэг дэх Ерөнхий Илтгэл, зүйл 29)

---

***Анхаарах зүйл:** Хорих өрөөнүүдийн хэт дүүргэлт ноцтой асуудал юм. Энэ асуудал ашигтай талбай (квадрат метрээр) ба түүн дотор амьдарч байгаа хүмүүсийн тооны харьцаанаас үүсдэг. Хоригдогсдын тоо хэт олширч хоригдогсдын дунд хүчирхийлэл үүсэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.*

---

### **Шалгах асуулт**

- Нэг хүнд оногдох талбайн хэмжээ стандартад нийцэх үү?
- Амьдрах байрандаа өдрийн хэдэн цагийг өнгөрүүлдэг вэ?
- Амьдрах байр цоожтой үед агааржуулалт ямар байдаг вэ?
- Үзлэг шалгалт хийхэд бусад хоригдогсдын хяналтаас хол байлгаж чаддаг уу?
- Хоригдогсдын амьдрах орчинд нь бусдын нөлөөгүйгээр ярилцах боломжтой юу?

## **ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

### **Нарлуулах арга хэмжээ**

Эрүүл агаарт ажил хийхгүй байгаа, бас хорих өрөөнөөсөө байнга гарах боломжгүй хоригдогсод цаг агаарын тохиромжтой нөхцөлд өдөр бүр наад зах нь нэг удаа гарч, биеийн тамирын дасгалыг хашаан дотроо хийнэ. Гяндан болон цагдан хорих төвд урьдчилан хоригдож байгаа хүмүүсийг аюулгүй байдлыг хангасан нөхцөл бүрдүүлэн нарлуулах шаардлагатай. Хорих ангийн ажилтны хүрэлцээ муу, аюулгүй байдал хангагдаагүй нь эрүүл агаарт байх эрхийг нь хязгаарлах үндэслэл болохгүй. Иймд хорих анги нь хуулиар тогтоосон цагт нарлагаанд хоригдогсодыг гаргахад хангалттай тооны харуулын ажилтан болон хяналтын бусад техник хэрэгсэлтэй байвал зохино.

1. Эрүүл агаарт ажил хийхгүй байгаа бүх хоригдол цаг агаар тохиромжтой бол өдөр бүр дор хаяхад нэг удаа зохих биеийн тамирын дасгалыг хашаан дотор хийх эрхтэй.

2. Бага насны бөгөөд эрүүл мэндийн байдлаас шалтгаалсан хоригдлуудад биеийн дасгал хийх, тэр үедээ тоглох боломжийн дасгал хийх явдлыг хангавал зохино. Үүний тулд шаардлагатай талбай, тоноглол, төхөөрөмжтэй байвал зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 21 дүгээр дүрэм)

Гадуур гарч ажилладаггүй буюу нээлттэй биш хорих газарт байдаг хоригдогч бүр, эсхүл задгай талбайгүй хорих газрын хоригдогсод цаг агаарын боломжтой нөхцөлд өдөрт нэг цаг эрүүл агаарт, цаг агаар таагүй нөхцөлд боломжтой бол дээвэртэй талбайд салхинд гарах, биеийн тамирын зохистой дасгал хийх боломж олгох хэрэгтэй.

(Европын шоронгийн дүрэм, 86 дахь дүрэм)

Эрүүл агаарт гарах ёстой тухай онцлон анхааруулж байна. Хоригдогсод өдөрт ядаж нэг цаг эрүүл агаарт биеийн тамирын дасгал хийх шаардлага нь хүний эрхийг хангах үндсэн баталгаа болж байгааг нийтээр хүлээн зөвшөөрдөг болсон. Энэ шаардлага үйл ажиллагааны илүү өргөн хүрээтэй хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болбол сайнсан. Бүх хоригдогсод, тэр дундаа шийтгэл хүлээж тусгаарлагдсан хоригдогч ч ялгаагүй өдөр бүр эрүүл агаарт биеийн тамирын дасгал хийж байх нь зүйтэй гэдгийг Хороо онцлон тэмдэглэж байна. Эрүүл агаарт хичээллэх талбай нь хангалттай зайтай, цаг агаарын таагүй нөхцөлд боломжийн хирээр бүрхүүлтэй байх нь зүйтэй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 56)

---

**Анхаарах зүйл:** *Бие засах, усанд орох зэргээр эрүүл ахуйн шаардлагаар өрөөндөө байхгүй хугацааг тооцохгүйгээр бүх хоригдогсод тохиромжтой цагт багаар бодоход нэг цагаар агаарт гарах, биеийн тамирын дасгал хийх боломжтой байх ёстой.*

---

### **Шалгах асуулт**

- Хорих өрөө, байрнаас гадуур ямар хугацаагаар байдаг вэ?
- Сахилгын байранд байгаа хоригдогчид нарлах, биеийн тамирын дасгал хийх боломжийг олгодог уу?
- Ажил хийдэг хоригдогсод энэ боломжийг яаж гаргаж өгдөг вэ?

### **ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

1/ Албадан саатуулах байранд холбогдох хууль, дүрмийг хатуу сахиулах зорилгоор уг байрыг шууд харьяалдаггүй байгууллагаас томилогдсон өндөр мэргэжилтэй, ажлын зохих туршлага эзэмшсэн, эрх бүхий өөр хүмүүс байнга очиж ажиллах ёстой.

2/ Саатуулагдсан буюу хоригдсон этгээд энэ зарчмын 1 дэх хэсэгт нийцсэн

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

саатуулах буюу хорих газрын аюулгүй байдал, дэг журмыг хангах ухаалаг нөхцлийг сахин, саатуулах буюу хорих газарт очиж байгаа хүмүүстэй бусдыг байлцуулахгүйгээр чөлөөтэй харилцах эрхтэй.

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 29 дүгээр зарчим)

Хорих байгууллага, албадыг эрх бүхий байгууллагын томилсон, мэргэшсэн туршлагатай хянан шалгагчид тогтмол шалгаж байх ёстой. Хянан шалгагчид тухайлбал хорих газрыг хууль, дүрмийн дагуу удирдаж, ажил нь хорих газар, засан хүмүүжүүлэх албадын өмнө тавьсан зорилгод нийцэж байгаа эсэхийг магадлаж байх ёстой.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 55 дугаар дүрэм)

Хоригдож буй этгээдээс гаргасан гомдолтой танилцаж, түүний дагуу шалгалт хийх хамгийн үр дүнтэй аргыг хэрэглэх нь хорих газарт хоригдогсодтой хэрцгий, хүнлэг бус харьцахын эсрэг баталгаа мөн. Хоригдогсод тухайн хорих, цагдан хорих газрын холбогдох удирдлага болон гадаад орчны холбогдох байгууллага, эрх баригчдад гомдол гаргах боломжоор хангагдсан байх ёстой. Хорих үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага бүрд хараат бус байгууллага жишээ нь, Уулзалт зохион байгуулагчдын зөвлөл, тухайн хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавихаар томилогдсон шүүгчид г.м хоригдогчийн гомдлыг хүлээн авч, түүний мөрөөр шалгах шаардлагатай бол холбогдох арга хэмжээ авах, түүнчлэн тухайн байгууллагыг бүхэлд нь шалгах эрх бүхий, төлөөлөгчид тогтмол очиж ажиллаж байх шаардлагатай байдаг гэдэгт Хороо онцгой анхаарал хандуулж байна. Ийм байгууллагууд нь бусад арга хэмжээний зэрэгцээ хорих, цагдан хорих газрын захиргаа болон хоригдогсдын хооронд үүсэх зөрчилдөөнийг арилгахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 54)

---

**Анхаарах зүйл:** Хорих, цагдан хорих газарт хийх дотоодын болон гадны хяналт шалгалт нь тодорхой хүчин зүйлүүдийг сайжруулах, ажилчдын үйл ажиллагааг үнэлэх, идэвхижүүлэх төдийгүй зарим бэрхшээлтэй асуудалд дээд байгууллагын анхаарлыг хандуулахад нөлөөтэй байдаг.

---

### **Шалгах асуулт**

- Хорих ангид ямар ямар байгууллага, газраас ямар чиглэлийн хяналт шалгалт хийгддэг вэ? Хяналт шалгалт хараат бус шударга байж чаддаг уу?
- Хяналт шалгалт тогтмол хийгддэг үү?
- Хяналтын баг ямар бүтэц бүрэлдэхүүнтэй байдаг вэ?
- Хяналт шалгалтаар ирсэн хүмүүстэй хоригдлын уулзах хүсэлтийг биелүүлдэг үү?
- Эдгээр байгууллага хоригдогсдын гомдлыг хүлээн авч, холбогдох арга хэмжээг авах эрх мэдэлтэй юу?

## **САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ**

Хоригдогсод болон хорих байрны ажиллагсдын эрх ашгийн үүднээс сахилгын арга хэмжээний тогтолцоог амьдрал дээр нарийвчлан авч үзэж, ямар нэг зүйл тодорхой бус байвал ялангуяа эмзэгийн дотор бүр эмзэг хэсэг болох насанд хүрээгүй болон эмэгтэйчүүд, сэтгэл зүй нь хэвийн бус байгаа хоригдогчдод сахилгын арга хэмжээг онцгой арга хэмжээг болгон хэрэглэх талаар сайн уламжлал туршлагыг авах талаар эрмэлзэх ёстой. Тухайлбал 1981 оны засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн 8 дугаар бүлгийн 51-д заасан жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг торгуулийн тусгаарлагдан байр, ганцарчилсан хатуу тасалгаа, гяндангийн чанга дэглэмд шилжүүлж болохгүй гэсэн нь эхчүүд, эмэгтэйчүүдийг хамгаалахад чиглэсэн байв.

1/ Саатуулагдсан болон хоригдсон этгээдүүд саатуулагдах буюу хоригдох үед гаргадаг сахилгын зөрчил гэж тооцогдох зан үйл шинж чанар, сахилгын арга хэмжээний төрөл, үргэлжлэх хугацаа, түүнийг оногдуулах эрх хэмжээ бүхий байгууллага зэргийг хуулиар болон хуульд нийцүүлэн гаргасан дүрмээр нарийвчлан тодорхойлох бөгөөд тэдгээр нь хэвлэгдсэн байх ёстой.

2/ Саатуулагдсан болон хоригдсон этгээд сахилгын шийтгэл ногдуулахаас өмнө тайлбар өгөх эрхтэй. Уг сахилгын арга хэмжээний талаар дээд шатны байгууллагад давж заалдах гомдол гаргах эрхтэй.

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 30 дугаар зарчим)

Сахилга дэг журмыг найдвартай хяналт, хамтын амьдралын зохих журмыг хангахад шаардлагатай хязгаарлалтыг л хэрэглэж хатуу сахиулбал зохино  
(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 27 дугаар дүрэм)

Дараахь зүйлийг хуулиар эсхүл эрх бүхий захиргааны байгууллагын шийдвэрээр тодорхойлох ёстой:

а/ Сахилгын зөрчилд тооцогдох зан үйл

б/ Хоригдолд оногдуулж болох шийтгэлийн төрөл, хугацаа

в/ Шийтгэл оногдуулах эрх бүхий байгууллага

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 29 дүгээр дүрэм)

Шүүх, харанхуй гянданд хорих болон хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилсон шийтгэлийн төрлийг сахилгын зөрчил гаргасны төлөө хэрэглэхийг хоригловол зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 31 дүгээр дүрэм)

Түүнчлэн хоригдогсод болон хорих байрны ажиллагсдын эрх ашгийн үүднээс сахилгын арга хэмжээний тогтолцоог амьдрал дээр нарийвчлан тодорхойлж албан ёсоор тогтоож хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Аль нэгэн зүйл нь тодорхой бус байх нь хууль бус тогтолцоо бий болгох эрсдэлтэй байдаг. Сахилгын арга хэмжээ авах тухай журамд хоригдогсод тэдний үйлдсэн гэх эрх зүйн зөрчлийн талаар тайлбар хийх, оноож байгаа сахилгын арга хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа холбогдох дээд байгууллагад илэрхийлэх эрхтэй. Харин

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

хорихын албан хаагч яагаад ийм арга хэмжээ авах болсныг хоригдогчид мэдэгдэх ёстой бөгөөд аюулгүй байдлыг хангахаас өөр шаардлага гараагүй бол тухайн асуудлаар саналаа хэлэх, дээд шатны байгууллагад гомдол гаргах боломжийг тэдэнд хангаж өгөх үүрэгтэй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 55)

Сахилгын арга хэмжээ авах албан ёсны журмын зэрэгцээ аюулгүй байдлыг хангах сахилга батын арга хэмжээг хорих байр дотроо бий болгож түүний үрээр хоригдогсод өөрөө хүсээгүй байхад бусдаасаа тусгаарладаг. Ийм журам тогтооходоо хоригдогсдын хүний эрхийг хангах баталгаатай байх ёстой.

---

***Анхаарах зүйл:** Сахилгын арга хэмжээ авах тухай журмыг хоригдогсдод амаар болон бичгээр түүнд ойлгомжтой хэлээр танилцуулж үзэх боломжтой газар байрлуулах ёстой. Мөн энэ журам эрх зүйн ямар зөрчилд, ямар хэлбэрийн шийтгэл оноохыг тусгасан байх ёстой. Түүнчлэн ямар нэг зөрчил гаргахгүй бол урамшуулах хэлбэрийг ч зааж өгвөл илүү үр дүнтэй болдог байна.*

---

### **Шалгах асуулт**

- Хэн, ямар үндэслэлээр (амаар болон бичгээр гаргасан илтгэх хуудас) шийтгэлийг тогтоох вэ?
- Ямар зөрчилд, ямар арга хэмжээг, хэдий хугацаагаар авдаг вэ?
- Юунд буруутгаж байгаагаа түүнд ямар сахилгын арга хэмжээ оногдуулсанаа хоригдогчид мэдэгдсэн үү?
- Хоригдогч өөрийгөө хамгаалах, тайлбар гаргах боломжтой юу?
- Давж заалдах гомдол гаргаж болох бол яаж зохицуулж, хэрхэн шийдвэрлэдэг вэ?
- Тухайн үед тодорхой нөхцөл байдлаас (эрүүл мэнд, ажлын шаардлагаас) шалтгаалан сахилгын шийтгэлийг хойшуулсан тохиолдолд нөхөж олгодог уу?
- Сахилгын шийтгэлийг нөхөж олгосон бол тухайн шийтгэл оногдсон үеийнхээсээ өөрчлөгдөөгүй зөрчилд тохирсон арга хэмжээ хэвээр байж чаддаг уу?
- Тодорхой нэг хоригдлын хийсэн зөрчлийн улмаас хэсэг бүлгээр нь, нийтээр нь шийтгэх, залхаах байдал гардаг уу? Ямар хэлбэрээр шийтгэдэг вэ?
- Байнга, тогтмол сахилгын шийтгэл аваад байдаг хоригдол ажиглагддаг уу? Тийм бол яагаад шийтгэл аваад байдаг вэ? Өөр арга хэмжээ авах боломж бий юу?

### **ГОМДОЛ ГАРГАХ ЖУРАМ**

1. Саатуулагдсан болон хоригдсон этгээд, түүний өмгөөлөгч нь тухайн этгээдтэй хэрхэн харьцаж байгаа тухайлбал эрүүдэн шүүх, хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж байгаа талаар саатуулах буюу хорих газрыг удирддаг буюу түүний дээд шатны байгууллагад шаардлагатай



тохиолдолд гомдлыг хянан үзэх, хамгаалах арга хэмжээ авах бүрэн эрх бүхий бусад зохих байгууллагад гомдол хүсэлт гаргах эрхтэй

2.Хэрэв саатуулагдсан болон хоригдсон этгээд түүний өмгөөлөгч энэ зарчмын 1 дэх хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд энэ эрхийг саатуулагдсан болон хоригдсон этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн энэ тухай мэдсэн аливаа бусад хүн эдэлж болно.

3.Гомдол, хүсэлт гаргасан этгээд хүссэн бол уг гомдол, хүсэлтийг нууц байлгана.

4.Гомдол, хүсэлт нэг бүрийг яаралтай авч хэлэлцээд хариуг үндэслэлгүйгээр удаашруулахгүй өгөх ёстой. Хэрэв гомдол, хүсэлтийг хангахаас татгалзсан хийгээд, үндэслэлгүй удаашруулсан тохиолдолд гомдол, хүсэлт гаргагч шүүхэд буюу бусад байгууллагад хандах эрхтэй. Саатуулагдсан болон хоригдсон этгээд эсхүл гомдол, хүсэлт гаргасан хэнийг боловч энэ зарчмын 1 дэх хэсэгт зааснаар тэднийг гомдол, хүсэлт гаргасны нь төлөө хяхан хавчих ёсгүй.

( “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” 33 дугаар зарчим)

1. Хоригдол бүр ажлын өдрүүдэд хорих ангийн дарга буюу бусад эрх бүхий ажилтанд өргөдөл, гомдол гаргах боломжтой байх ёстой.

2. Шалгалтын үед хоригдлууд хорих ангийн ажилтнуудад хүсэлт, гомдол гаргах бололцоотой байх ёстой. Тэд байцаагч, эсхүл шалгалтын бусад хүмүүстэй захирал, бусад ажилтнуудын эзгүйд ярилцах эрхтэй байх ёстой.

3. Хоригдол бүр хорих ангийн захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүсэлт өргөдлөө гаргах боломжтой байх ёстой бөгөөд тэдгээрийг агуулгын талаас хянахгүйгээр зохих хэлбэрийн дагуу бүрдүүлж тогтоосон журмаар шоронгийн төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүргэж байвал зохино.

4. Тийм хүсэлт, гомдол, хэлбэрийн төдий, утгагүй шинжтэйгээс бусад тохиолдолд түүнийг яаралтай хянан шийдвэрлэж хэт удаашруулалгүй хариу өгөх ёстой.

( “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 36 дугаар дүрэм)

---

**Анхаарах зүйл:** Дотооддоо, хорих, цагдан хорих газрын даргад хандаж гаргах гомдол, хоригдогч шаардлагатай гэж үзвэл дээд шатны удирдах байгууллагад зэргээр гомдол хэд хэдэн төрөлтэй байдаг. Гомдлын агуулга, ямар шатанд гаргаж байгаагаас үл шалтгаалан гомдлыг шийдүүлэх ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Гомдол гаргах журам хоригдогсдод бүгдэд нь боломж олгодог уу?
- Гомдлын төрлөөс хамаарч хэнд хандаж, ямар журмаар гаргадаг вэ?
- Хорих, цагдан хорих газрын захиргаанд давах шатны гомдол гаргах боломжтой юу?
- Хорих ангийн дотоодод гаргасан гомдлыг ямар хугацаанд шийдүүлж болох вэ?
- Хяналт шалгалтын байгууллагад гомдол гаргах боломжтой юу?

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

- Хамтын буюу хоригдлуудын дундаас захиргаанд гаргасан гомдолд хоригдлуудын хэн нэгнийг буруутгах тохиолдол гардаг уу?
- Гомдол гаргахыг ямар нэг байдлаар хязгаарладаг уу?

### **Нэмж унших материал**

- Шарон Шалевийн “Ганцаарчилан хорих тухай гарын авлага” A sourcebook on solitary confinement. Sharonm Shalev, LSE 2008
- Хоригдлуудтай харилцах наад захиын жишиг дүрэм
- Европын орнуудын сайд нарын хорооны 1987 оны 12 дугаар сарын 17, Европийн шоронгийн дүрэм
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс- 12 сарын 31-ны хоорондох тайлан илтгэлээс
- Монгол улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн түүхэн хөгжил /1931-2005/, 2005 он. 120 дахь тал
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл /2008 он/
- Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь гарын авлага. 2005 он. Эмнести Интернэшнл

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

Хорих, цагдан хорих асуудал нь хүмүүст өөрийн амьдралаар амьдрах боломж олгодоггүй учраас хоригдогсдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжиж байх нь чухал. Тиймээс хорих үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх баригчид хоригдогсдын эрүүл мэндийг хангалттай түвшинд байлгах нөхцөл, амьдрах ба хөдөлмөрлөх эрүүл нөхцөл болон холбогдох эмнэлгийн үйлчилгээгээр хангах ёстой. Түүнчлэн хоригдогсодын бие махбодийн болон сэтгэл зүйн үнэт зүйлсийг зөрчихөөр эмнэлгийн туршилт хийхийг хориглодог.

Эрүүл мэндийн үйлчилгээ нь эрх чөлөөт амьдралдаа авдаг үйлчилгээнээс ялгагдах ёсгүй. Хорих явдал нь хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндэд нөлөөлдөг учраас эмнэлгийн үйлчилгээ нь чухал асуудал юм.

Хоригдогсодын сэтгэцийн эрүүл мэндэд биеийн эрүүл мэндийн адил анхаарал хандуулбал зохистой. Ингэхдээ эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ бус сэтгэл заслын чиглэлээр ажиллах нь илүү тохиромжтой. Ял эдлэх боломжтой гэж үзсэн хоригдолууд дотор тодорхой тооны хоригдлууд сэтгэцийн өөрчлөлтэй байдаг бөгөөд үүнийг эмч үзэж тогтоогоод эрүүл хоригдлуудаас тусад нь байлгавал зохимжтой. Иймд хорих анги нь хамгийн наад зах нь хорих ангийн эмч, нийгмийн ажилтнуудыг энэ чиглэлд тусгайлан мэргэшүүлэх шаардлагатай.

### **Эрүүл мэндийн үйлчилгээ:**

- § Эмнэлгийн үйлчилгээ авах боломж
- § Эмэгтэйчүүд ба хүүхдийн эмнэлгийн үйлчилгээ
- § Эмнэлгийн боловсон хүчин

## **ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БОЛОМЖ**

Олон улсын хүний эрхийн байгууллага бүх улс орны хүмүүс “шорон бол эрүүл аюулгүй орчин байх” нь цаанаа учир шалтгаантай том асуудал гэдгийг хэлж байгаа билээ. Хорих цагдан хорих асуудал нь хүмүүст өөрийн амьдралаар амьдрах боломж олгодоггүй учраас хоригдогсдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжиж байх учиртай. Хорих явдал нь хоригдогчийн бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндэд нөлөөлдөг учраас эмнэлгийн үйлчилгээ нь чухал асуудал юм.

Шинээр ирсэн хоригдогчид хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтан тэр даруй үзлэг хийх ёстой.

Хорих, цагдан хорих газар ирснээс нь хойш хамгийн богино хугацаанд, цаашдаа шаардлагатай үед нь хоригдогч бүрийг эмчийн үзлэгт хамруулж бие махбодийн болон сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тодруулж, түүнийг эмчлэхийн тулд шаардлагатай бүх хэрэгслийг ашиглаж, халдвар тээж байж болзошгүй хоригдогсодыг тусгаарлаж, суллагаад нийгэмд гарахад нь саад болохуйц бие махбодийн болон сэтгэцийн гажилтыг тодорхойлж, түүнчлэн хоригдогч бүрийн хөдөлмөрлөх чадварыг тогтооно.

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

(Европын шоронгийн дүрэм, 29 дэх дүрэм)

1. Хоригдогсодын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндэд эмнэлгийн нормонд заасны дагуу үе шаттайгаар үзлэг хийдэг, өвчилсөн, гэмтэл авсан, шархадсан болон онцгой анхаарах ёстой хоригдогсдыг үздэг эмч хяналт тавина.

2. Эмнэлгийн ажилтан хоригдогчийг цаашид хорих, эсхүл тодорхой нөхцөлд хорих нь түүний бие, сэтгэцийн эрүүл мэндэд хортой нөлөөлсөн болон нөлөөлөхөөр байгаа тохиолдол бүрд энэ тухай хорих байрын даргад илтгэнэ.

(Европын шоронгийн дүрэм, 30 дахь дүрэм)

Бүх төрлийн хорих байгууллага өөрийн мэдэлд ядахдаа нэг сэтгэгц судлалын зохих мэдлэгтэй эмнэлгийн мэргэжилтэн ажилтантай байх ёстой. Хэрэв хүүхэд шоронд төрсөн бол энэ тухай төрсний гэрчилгээнд тэмдэглэхгүй байх нь зүйтэй.

Саатуулагдсан болон хоригдсон этгээд өөрөө зөвшөөрсөн байсан ч эрүүл мэндийг нь муутгаж болох ямар нэг эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт явуулах ёсгүй.

( "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц"-ын 22 дугаар зарчим)

Шинээр ирсэн хоригдогчид хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтан тэр даруй үзлэг хийх ёстой. Хоригдогч бүрийг ирмэгц нь зохих ёсоор биеийн байцаалтыг авч, шаардлагатай бол бүтэн биений үзлэг хийх тухай Хороо тайлангууддаа зөвлөсөн. Зарим улс орнуудад шинээр ирсэн хоригдогчийг эрх бүхий сувилагч үзэж үзлэгийн дүнг эмчид танилцуулдаг журам байдгийг хэлэх нь зүйтэй. Энэ нь байгаа нөөц бололцоогоо үр дүнтэй ашиглаж байгаа хэрэг юм.

Түүнчлэн шинээр ирэгсдэд эмнэлгийн албаны үйл ажиллагаа болон хувийн ариун цэврийг сахих үндсэн арга хэмжээний тухай гарын авлага өгч байх нь зүйтэй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 33)

Хоригдогсод дэглэмээсээ үл шалтгаалан шаардлагатай үедээ эмчид үзүүлэх боломжтой байх ёстой.

(Ганцаарчилан хоригдож байгаа хоригдогчийн эмнэлгийн үйлчилгээ авах боломжийн талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь ерөнхий илтгэлийн зүйл 56-г үз).

Эмнэлгийн үйлчилгээ нь эмчээс зөвлөгөө авах хүсэлт гаргасан тохиолдолд элдэв саадгүй гүйцэтгэгддэг байхаар зохион байгуулагдах нь зүйтэй.

Хоригдогсдод эмчид ганцаарчлан хандах, жишээ нь битүүмжилсэн дугтуйнд өргөдөл бичиж өгөх зэрэг боломж олгох ёстой. Түүгээр ч зогсохгүй тухайн хоригдогчийн эмчид үзүүлэх тухай хүсэлтийг хорих, цагдан хорих газрын

ажилтнууд заавал шалгах гэж зүтгэх ёсгүй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 34)

**Анхаарах зүйл:** Хоригдогсдод үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний чанар нь хорих системийн бус нөхцөл дэх эмнэлгийн үйлчилгээний чанараас ялгагдах ёсгүй.

### **Шалгах асуулт**

- Ойр зуурын эм тариаг өөрсөд дээрээ байлгаж болох уу? Тийм бол түүнийг хаанаас хэнээс авдаг вэ? Эмийн хэрэглээ, хадгалалтанд ямар хяналт, шалгалт тавьдаг вэ?
- Нийт хоригдлуудыг тогтмол үзлэгт хэзээ хамруулдаг вэ? Ямар ямар үзлэг шинжилгээ хийгддэг вэ?
- Ямар нэг хууч өвчтэй хоригдогчдод байнгын эмнэлгийн тусалцаа үзүүлж хяналтад байлгадаг уу?
- Эмчилгээний зардлыг хэрхэн зохицуулдаг вэ?
- Хоригдогсдод эмнэлгийн үйлчилгээ авах боломж ямар вэ? Хэрэв тэд өөрсдөө хүсвэл ямар боломжтой вэ?
- Ажилтны хүсэлтээр бол ямар шалгууртай вэ?
- Эмнэлгийн ажилтнууд хоригдогсдыг тогтмол эргэдэг үү?
- Эмнэлгийн ажилтан хоногоор жижүүрлэдэг үү?
- Өдөр, шөнийн аль ч цагт эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтсон журам бий юу?
- Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, ном гарын авлага, танилцуулга, зурагт хуудас хэр хүртээмжтэй вэ

### **ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

Хоригдогч эмэгтэйчүүдийн хувьд эрүүл мэндийн тэгш эрхийн зарчмыг мөрдлөг болгон тэдний эрүүл мэндийг хамгаалах ажлыг эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч болон энэ талаар мэргэжлийн бэлтгэл хангасан эмч, сувилагч нараар гүйцэтгүүлнэ. Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах тусгайлсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ буюу хөхний болон умайн хүзүүний хавдар зэргийг оношлох ажиллагааг эрх чөлөөтэй эмэгтэйчүүдийн эмнэлэгт үзүүлдэг эмнэлгийн үйлчилгээнийнэгэн адил хийгдэнэ.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 32)

1. Эмэгтэйчүүдийн хорих газар нь жирэмсэн болон төрсөн эхчүүдийг асрах тусгай өрөөтэй байх ёстой. Боломжтой газарт эмэгтэйчүүдийг хорих ангид нь бус ердийн эмнэлэгт төрүүлэхэд анхаарвал зохино. Хэрэв хүүхэд хорих ангийн доторхи эмнэлэгт төрсөн бол энэ тухай төрсний гэрчилгээнд тэмдэглэхгүй байх нь зүйтэй.

2. Хоригдол эхчүүдэд хүүхдээ өөртэйгээ байлгахыг зөвшөөрдөг бол тэдгээр хүүхдийг эхээс тусдаа байх үед нь асрах мэргэжлийн ажиллагсадтай ясли байгуулах хэрэгтэй.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 23 дугаар дүрэм)

1. Боломжтой газар жирэмсэн эхийг ердийн эмнэлэгт төрүүлэх талаар арга хэмжээ авна. Гэхдээ ийм боломжгүй бол хорих ангийн эмнэлэгт хүүхэд төрүүлэх болон төрсний дараа эх, хүүхдийг асрах мэргэжлийн боловсон хүчин, зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх ёстой. Хэрвээ хүүхэд хорих газар төрсөн бол энэ тухай түүний төрсний гэрчилгээнд дурьдах ёсгүй.

2. Хэрвээ хүүхдийг эхтэйгээ үлдэхийг зөвшөөрвөл хорих байгууллага мэргэжлийн багш ажилладаг ясли байгуулж хүүхдийг эхээсээ тусдаа байгаа үед нь асарна.

(Европын шоронгийн дүрэм, 28 дахь дүрэм)

Хүүхэд хорих байранд болон хорих ангийн эмнэлэгт төрөх ёсгүй. Тиймээс Европын Зөвлөлийн гишүүн орнуудад жирэмсэн эхчүүдийг төрөх үед нь ердийн төрөх эмнэлэгт шилжүүлдэг тогтсон туршлагатай болжээ. Гэвч жирэмсэн эхчүүдэд үзлэг хийх, төрөх үед нь гарт нь гав хийж, эсхүл өөр аргаар ор болон тавилга хэрэгсэлд хүлэх явдал гарсаар байна. Ийм хандлага огт байх ёсгүй бөгөөд үүнийг хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон гутаасан харьцаа гэж шууд тодорхойлж болно. Ийм тохиолдолд аюулгүй байдлыг хангах өөр арга хэрэгсэл байж болно, байх ч ёстой.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1999 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 27)

---

***Анхаарах зүйл:** Хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтнууд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулах, эмэгтэйчүүдийн эмчийн үйлчилгээг баталгаатай авдаг байх ёстой. Хорих байр нөхцөл, байдлаа жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхэдтэй эхчүүдийн онцгой хэрэгцээг хангах ёстой.*

---

### **Шалгах асуулт**

- Хорих, цагдан хорих газарт мэргэжлийн эмэгтэйчүүдийн эмч ажилладаг уу? Хэзээ, ямар цагт хүлээж авдаг вэ?
- Хэрвээ байхгүй бол тогтмол хугацаанд хүсэлтийн дагуу үзлэгт хамрагдах боломжтой юу?
- Эмэгтэйчүүдийн эмчийн үйлчилгээг авахын тулд ямар нэг болзол хангасан байх ёстой юу?
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээ хангагддаг уу?
- Нярай хүүхэдтэй хөхүүл эхчүүдийн онцгой хэрэгцээ хангагддаг уу?
- Шаардлагатай витамин, нэмэлт тэжээлийг авч хэрэглэхэд ямар нэг нөхцөл шаардлага тавигддаг уу?

## **ЭМНЭЛГИЙН БОЛОВСОН ХҮЧИН**

1. Хоригдогсдын бие, сэтгэлийн эрүүл мэндэд эмнэлгийн нормонд заасан үе шатлалтайгаар, мөн өвчилж, шархадсан, гэмтэл авсан хоригдогсдыг өөрсдийнх нь хүсэлтээр, түүнчлэн онцгой анхаарал шаарддаг хоригдогсдыг үздэг эмнэлгийн ажилтан хяналт тавина.

2. Хоригдогч цаашид хоригдох боломжгүй, эсхүл хорих ямар нэгэн нөхцөл эрүүл мэндэд нь хортойгоор нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байгаа тохиолдол гарах бүрд эмнэлгийн ажилтан хорих, цагдан хорих газрын даргад энэ тухай илтгэнэ.

(Европын шоронгийн дүрэм, 39 дэх дүрэм)

1. Бүх хорих байгууллага өөрийн мэдэлд ядахдаа нэг сэтгэц судлалын зохих мэдлэгтэй эмнэлгийн мэргэжлийн ажилтантай байх ёстой. Эмнэлгийн үйлчилгээг орон нутгийн болон улсын эрүүлийг хамгаалах байгууллагуудтай нягт холбоотой зохион байгуулбал зохино. Энэ сэтгэц зүйн оношлогооны албыг шаардлагатай газарт байлгах ёстой бөгөөд сэтгэцийн гажигтай хоригдлуудын эмчилгээг хамрах ёстой.

2. Мэргэжлийн эмчилгээ шаардлагатай өвчтөн хоригдлыг тусгай, эсхүл ердийн эмнэлэгт хэвтүүлбэл зохино. Шоронгийн эмнэлгүүд өвчтөнийг зохих ёсоор сувилах эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эмтэй байхаас гадна эмнэлгийн хангалттай мэргэшсэн ажилтнуудтай байвал зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 22 дугаар дүрэм)

1. Хорих, цагдан хорих газар бүрд ядахдаа нэг дотрын эмч ажиллах ёстой. Эмнэлгийн үйлчилгээг тухайн орон нутгийн эрүүлийг хамгаалах байгууллагатай нягт хамтран зохион байгуулах ёстой.

2. Эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж хэрэгтэй байгаа өвчтэй хоригдогчийг нарийн мэргэжлийн эмнэлгийн байгууллага болон ердийн эмнэлэгт шилжүүлэх ёстой. Хорих, цагдан хорих газарт эмнэлэг ажилладаг тохиолдолд эмнэлэг нь байр, тоног төхөөрөмж, эм, эмийн бэлдмэл зэрэг өвчтэй хоригдогчид эмчилгээ хийх, асрахад шаардлагатай зүйлсээр болон мэргэжлийн ажилтнуудаар хангагдсан байх ёстой.

3. Хоригдогч бүр мэргэжлийн шүдний эмчийн үйлчилгээ авах боломжоор хангагдсан байх ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 26 дахь дүрэм)

Хорих, цагдан хорих газрын эмнэлгийн алба нь ядахдаа амбулаториор зөвлөгөө өгөх, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх (түүнчлэн эмнэлгийн шинжтэй ортой тасагтай) чадвартай байх ёстой. Хоригдогч бүр мэргэжлийн шүдний эмчийн үйлчилгээ авах боломжтой байх ёстой. Үүнээс гадна хорих, цагдан хорих газарт ажиллаж байгаа эмч нарт мэргэжлийн эмч нарыг урьж ажиллуулах боломжийг хангасан байх ёстой.

Эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай болсон үед эмч дуудах боломж байнга байх ёстой. Үүнээс гадна хорих, цагдан хорих газарт анхны тусламж үзүүлэх чадвартай, боломжтой бол мэргэжлийн сувилагч байнга байх ёстой.

Эмчилгээ үргэлжлүүлэн хийх шаардлагатай тохиолдолд зөвхөн хоригдогчийн санаачилгад тулгуурлах нь ихэнх тохиолдолд хангалтгүй байдаг учраас эмнэлгийн ажилтнууд амбулаторийн эмчилгээнд байнга хяналт тавих ёстой.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 35)

Аль ч хорих, цагдан хорих газрын эмнэлгийн ажилтан эрсдэлд өртөх магадлал өндөртэй байдаг. Эмнэлгийн ажилтан үйлчлүүлэгчээ (өвчтэй хоригдогч) асарч халамжлах үүрэгтэй байдгаас байнга байгууллагын захиргааны үзэл бодол болон аюулгүй ажиллагааны арга хэмжээтэй зөрчилдөх тохиолдол гардаг. Энэ нь ёс зүйн хүндрэлтэй асуудлуудыг үүсгэж, сонголт хийх шаардлага тулгадаг.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1992 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Гуравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 71)

---

***Анхаарах зүйл:** Эмнэлгийн ажилтнууд хорих, цагдан хорих газрын захиргаанаас бүрэн хараат бус байх ёстой бөгөөд мэргэжлийн ёс зүй, эмнэлгийн үйлчилгээний чанар зэргийг өндрөөр хангаж ажиллана.*

---

### **Шалгах асуулт**

- Хэдэн эмч, сувилагч, сэтгэл зүйч, сэтгэцийн эмгэгийн эмч, эмнэлгийн өөр боловсон хүчинтэй вэ?
- Тэдний үйлчилгээг авах боломжтой юу? Ямар цагаар үйлчилдэг вэ?
- Эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг хорих ангиас бусдад эмнэлгийн ажилтны тоо, хоригдлын тоонд харьцуулахад хүрэлцэхүйц байж чаддаг уу?
- Эмнэлгийн эмч, ажилчид мэргэжил дээшлүүлэх боломж хэр байдаг вэ? Жилд хэдэн удаа сургалтад хамрагддаг вэ?
- Хорихын эмч ажилчдын хувьд мэргэжлийн ур чадвараас гадна тусгайлан эзэмших шаардлагатай ямар мэдлэг чадвар байдаг вэ?

### **Нэмж унших материал**

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц
- Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмын цогц
- Европын Зөвлөлөөс 1950 онд баталсан Европын Хүний Эрхийн Конвенц.
- Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм,
- Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын хүний эрхийн талаар баримтлах 10 үндсэн жишиг хэмжээ, 2000 он. Эмнести Интернэшнл
- Хуульчийн болон мэргэжлийн ёс зүйн дүрмүүд
- НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрмүүд/



## **АШИГТАЙ ХӨДӨЛМӨР**

Харуул хамгаалалтын зохих шаардлага хангаагүй, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журам биелүүлээгүй тухайн хоригдогчийг ажиллуулж болохгүй гэсэн тодорхойлолт гарсан нөхцөлд насанд хүрээгүй хоригдогчийг бүтэн цагаар ажиллуулахыг хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллуулахыг, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийг ажиллуулахыг, баривчлах ял эдлэж байгаа хоригдогсдыг хөдөлмөрлүүлэхийг тус тус хориглоно. Чанга онцгой дэглэмтэй хоригдлыг аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр ажиллуулахыг хориглоно. Жирийн дэглэмтэй хоригдлыг аж ахуйн нэгж байгууллагад ажиллуулахдаа мөрдөж буй үнэлгээ нормыг зөрчих, хөдөлмөрийн хуулинд тогтоосон цагаас илүү уртасгасан цагаар ажиллуулахыг хориглоно. Хоригдлын хөдөлмөрийн норм үнэлгээ цалин хөлс түүний нэрийнх дансны үлдэгдлийн талаар хариуцсан нягтлан бодогч нь сар тутам хоригдогсдод мэдээлж байна.

1. Хоригдлуудын хөдөлмөр нь тэднийг зовоох, шаналгах шинжтэй байх ёсгүй.

2. Бүх хоригдлууд нь эмчийн баталсан тэдний биеийн болон сэтгэл зүйн онцлогт таарсан хэмжээгээр хөдөлмөрлөх үүрэгтэй.

3. Хоригдлын жирийн ажлын өдрийг нийгэмд болон өөрт нь тустай ажлаар бүрэн хангах ёстой.

4. Хоригдлыг ажлаар хангах нь юуны өмнө тэднийг хорих газраас суллагдсаны дараа шударга хөдөлмөр эрхлэхэд нь туслах, ур чадварыг бий болгох, дээшлүүлэхэд оршино.

5. Иймд (ялангуяа насанд хүрээгүйчүүд) өөрсдөд нь тус болохуйц ажил хийхэд сургах ёстой.

6. Хорих газрын удирдлага зохион байгуулалт дэглэм шаардлагад нийцэх бол хоригдлыг хүссэн ажлаа өөрөө сонгож хийх бололцоогоор хангах ёстой.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 71-76 дүгээр дүрэм)

1. Хорих байранд хөдөлмөр зохион байгуулалт ба арга ажиллагаа нь боломжийн хэрээр тухайн төрлийн хөдөлмөрт нийгэмд тавигддаг шаардлагатай ижил байх ёстой. Ингэснээр хоригдогсдыг нийгмийн амьдралд гарч чөлөөт хөдөлмөр эрхлэх хэвийн нөхцөлд бэлдэнэ. Тиймээс тухайн хөдөлмөр нь үйлчилж байгаа норм норматив, техникийн шаардлагад нийцэж байх ёстой бөгөөд орчин үеийн удирдлагын арга барил, үйлдвэрлэлийн процессийн хүрээнд хэрэгжих ёстой.

2. Хоригдлын хөдөлмөрөөс санхүүгийн ашиг олохыг эрмэлзэх явдал нь чанарын түвшинг дээшлүүлж, мэргэжлийн бэлтгэлийн зорилго, чиглэлийг чанаржуулахад сайн нөлөөтэй боловч хоригдогсдын эрх ашиг ба тэднийг засан хүмүүжүүлэх ажлыг энэ зорилгод хамаатуулж болохгүй.

(Европын шоронгийн дүрэм, 38 дахь дүрэм)

---

**Анхаарах зүйл:** Хөдөлмөр эрхлэх асуудал нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нийцсэн, шийтгэлийн шинжгүй байх бөгөөд тохирсон үнэлгээ урамшуулалтай байх ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Ашигтай хөдөлмөр сайн дурын шинжтэй байдаг уу? Ямар төрлийн ажил хийхээ өөрөө сонгож болох уу?
- Эрхлэж байгаа хөдөлмөрийн төрөл нь суллагдсаны дараа таны амьдралд хувь нэмэр оруулахуйц байж чадах уу?
- Нэрийн дансан дахь мөнгөө авч ашиглахад ямар нэг нөхцөл шаардлага тавигддаг уу?
- Ажлын нөхцөл онцлог зэргээс шалтгаалан тухайн ажлыг хийхээс өмнө, тодорхой хугацаанд эмчийн үзлэгт ордог уу?
- Хорих, цагдан хорих газарт ашигтай хөдөлмөр эрхлэх боломж хэр вэ?
- Хоригдогч гадуур ажил эрхлэх боломжтой юу?
- Ажлын нөхцөл ба ажлын хөлс ямар вэ?
- Хөдөлмөрийн хөлсний түвшинг хэн тогтоодог вэ?
- Хөдөлмөрийн хөлсийг хоригдогсдод хаанаас хуваарилдаг вэ? Хуваарилалт хэрхэн явагдаж байгааг хоригдогчид мэдээдэг үү?

### **Нэмж унших материал**

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 онд батлагдсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
- Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм.
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий илтгэл
- “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”
- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 12-дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”
- ШШГ тухай Монгол улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, 2008 он, 202-207 дахь тал

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## **ХОРИХ, ЦАГДАН ХОРИХ ГАЗРЫН АЛБАН ХААГЧИД**

Албан хаагчийн жинхэнэ мэргэжлийн шинж чанар гэдэг нь хоригдогсодтой харьцахдаа нэгэн зэрэг аюулгүй байдал, дэг журам анхаарал хандуулж хүнлэг энэрэнгүй, зохистой харьцах чадвар юм. Иймд хорих, цагдан хорих газрын удирдлага боловсон хүчнээ хоригдогсод зохих ёсоор биеэ авч явахад бэлэн байгаа гэдэг зохих түвшний итгэлтэй байдалд чиглүүлэх ёстой. Албан хаагчид, хоригдогсдын хооронд зохион байгуулалттай, эерэг харилцаа тогтоосноор хүчирхийллийн эрсдэл буурах төдийгүй хяналт болон аюулгүй байдлыг улам хүчтэй болгоно. Ингэснээр албан хаагчид ч ажлаасаа ихээхэн таашаал авах боломжтой болно.

Албан хаагчид ба хоригдогсдын дунд эерэг харилцаа тогтоох нь хорих бүс ба янз бүрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоригдогсдын байруудад аль ч цагт хангалттай тооны албан хаагчид байхаас ихээхэн шалтгаалдаг. Нийтдээ боловсон хүчин хүрэлцэхгүй, албан хаагчдын тодорхой тогтоосон ажлын хуваарь байхгүй байгаа нь хоригдогсодтой шууд харилцах боломжийг багасгаж, эерэг харилцаа хөгжүүлэхэд илт саад болж, албан хаагчдын хувьд ч, хоригдогсдын хувьд ч таагүй орчныг бий болгож байна.

Боловсон хүчин хангалтгүй байгаа газарт аюулгүй байдал, байгууллагын хэвийн ажиллагааг хангахын тулд ихээхэн хэмжээгээр илүү цагаар ажиллах шаардлага гардаг. Ийм байдал нь албан хаагчдын стрессийг хэт өндөрсгөж, тэдний хүчийг барж байна. Энэ нь хорих, цагдан хорих аль ч газарт байдаг хүндрэлийг улам л ихэсгэж байна.

### **Харилцааны соёл ба хоригдогсдыг удирдах ажлын журмыг сайн мэдэхийн тулд:**

Албан хаагчид мэргэжлийн тусгай бэлтгэл хийсэн байх

Хангалттай цалинтай байх

Хоригдогсдын тоонд шаардлагатай тооны боловсон хүчинтэй байх

Ажлын хүнд нөхцөлд тохирсон ажлын цагтай, ажиллах нөхцөлтэй байх

Сургалт хариуцсан ажилтнууд /боловсрол эзэмшүүлэх, хичээллүүлэх, ажиллуулах/

### **Хорих, цагдан хорих газрын албан хаагчид:**

§ Ерөнхий байдал

§ Мэргэжлийн бэлтгэл

## **ЕРӨНХИЙ БАЙДАЛ**

1. Хорих, цагдан хорих газрын удирдлага бүх төрлийн боловсон хүчнээ нягтлан сонгоход онцгой санаа тавих ёстой бөгөөд тэдний хариуцлага, хүнлэг чанар, мэдлэг, хувийн чанараас нь шоронгийн үйл ажиллагаа сайн байх эсэх ихээхэн хамаарна.

2. Хорих, цагдан хорих газрын захиргаа нь өөрийн ажилтнуудад болон олон нийтэд нийгмийн онцгой ач холбогдолтой үүрэг гүйцэтгэж байгаагаа ухамсарлуулах талаар цуцалтгүй ажиллах ёстой.

3. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны ажилтнуудыг байнгын

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

орон тоонд төрийн албан хаагчийн статустай шоронгийн захиргааны мэргэжлийн ажилтнуудын хувиар сайн үр дүнтэй ажиллаж, биеийн эрүүл мэндийн хувьд хүлээлгэсэн зорилгыг биелүүлж чадаж байгаа нөхцөлд албан тушаалыг нь хадгална гэдэгт итгэлтэй байлгахгаар томилж байвал зохино. Тэдний ажлын хөлс нь энэ ажлыг хийж чадах чадварлаг эрэгтэй, эмэгтэй аль ч хүн татагдахаар тооцож тогтоосон байх ёстой. Энэ нь ажлын онцгой хүнд нөхцлийг нь харгалзан, эдгээр хүмүүст зохих хөнгөлөлт, ажлын нөхцлийг хангавал зохино.

(“Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”, 46, 54 дүгээр дүрэм )

Ажилтан хорих, цагдан хорих газрын зохих ёсны удирдлагаар хангагдах, зохион байгуулалтын хувьд төлөвлөсөн зорилгоо хэрэгжүүлэх ба хоригдогсодтой харилцах харилцаанд онцгой чухал үүрэг гүйцэтгэдгийг анхааралдаа авч хорих, цагдан хорих газрын захиргаа боловсон хүчнийхээ хувьд дагаж мөрдөх журмаа нэн тэргүүний зорилт гэж авч үзэх ёстой.

(Европын шоронгийн дүрэм, 51 дэх дүрэм)

Хорих, цагдан хорих газарт боловсон хүчнээ аль ч хүйсийн хүмүүсээр холилдуулан бүрдүүлэх нь хэрцгий, хүнлэг бус харьцаанаас хамгаалах чухал хамгаалалт байдаг. Эдгээр боловсон хүчин эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэнээр сэтгэл зүйн уур амьсгалыг бэхжүүлэх, тодорхой түвшинд хэвийн байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Аравдахь Ерөнхий Илтгэл, зүйл 23)

---

***Анхаарах зүйл:** Хорих газрын ерөнхий уур амьсгалыг бүрдүүлэхэд Хорих байгууллагын албан хаагчид голлох үүргийг гүйцэтгэдэг. Тиймээс албан хаагчдыг ажилд авахдаа тэдний ажиллах дадал туршлага, ур чадвар, чанарыг тодорхойлох тодорхой шалгуурт үндэслэх нь зүйтэй. Мөн аюулгүй байдлыг хангах, хоригдогсодтой хүний ёсоор харьцахад хүрэлцэхүйц хангалттай тооны байх ёстой.*

---

### **Шалгах асуулт**

- Хоригдогсдын тоонд албан хаагчдын тоог харьцуулсан дүн
- Эзэмшсэн боловсрол, үндсэн мэргэжил ба хувийн байдал зэрэг ажилд орох шалгуурууд
- Ажилд орсноос хойшхи мэргэжлийн бэлтгэл
- Ахиж дэвшсэн байдал, нөлөөлсөн хүчин зүйл
- Ерөнхий газраас болон хорих ангиас үзүүлдэг хангамж, хөнгөлөлт тэдгээрийг эдлэх нөхцөл шаардлага
- Дундаж цалин болон сард ажилладаг илүү цаг түүнийг тооцож урамшуулах арга

### **МЭРГЭЖЛИЙН БЭЛТГЭЛ**

Хороо эцэст нь хууль хяналтын байгууллагын ажилтнуудын мэргэжлийн бэлтгэлд (тэр дундаа хүний эрхийн салбарын талаар мэдээлэл НҮБ-ын Эрүүдэн

шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах ба шийтгэхийн эсрэг конвенцийн 10 дугаар зүйл) чухал ач холбогдол өгч байгаагаа тэмдэглэж байна. Зохих ёсоор бэлтгэгдсэн цагдаа ба хорих байгууллагын ажилтан хоригдогсодтой хэрцгий, хүнлэг бусаар харьцахын эсрэг хамгийн сайн бэлтгэгдсэн байх ёстой. Өндөр мэргэжлийн, сайн бэлтгэгдсэн албан хаагч нь хэрцгий, хүнлэг бус харьцааг хэрэглэхгүйгээр, хоригдсон ба саатуулагдсан этгээдийн үндсэн баталгаат хүний эрхийг хангаж амжилттай харьцах чадвартай.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 59)

Энэ үүднээс Хороо, хууль хяналтын байгууллагын ажилтныг ажилд авах үндсэн шалгуур нь хүнтэй харилцах чадвар хэмээн ойлгож байна. Тиймээс боловсон хүчнийг бэлтгэх сургалтын явцад хүний нэр хүндийг хүндэтгэсэн харилцааны дадлыг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй. Ийм дадал эзэмшсэн цагдаа болон хорих байгууллагын ажилтан хүчирхийлэлд хүрч болзошгүй тохиолдолд ч байдлыг намжааж, харьяалагдаж байгаа байгууллагынхаа хүндрэлийг бууруулж, хэвийн ажлын түвшинг дээшлүүлж аль аль талдаа ашигтай байдлыг бий болгох чадвартай байдаг.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 60)

---

**Анхаарах зүйл:** Хорих, цагдан хорих газрын албан хаагчдын мэргэжлийн бэлтгэлд хүмүүсийн хоорондын харилцаа, үүссэн асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, стрессээ удирдах зэрэг бэлтгэлүүд байх ёстой бөгөөд энэ нь хорих тогтолцоог хүмүүнлэг байлгах суурь үндэс юм.

---

### **Шалгах асуулт**

- Хорих, цагдан хорих газрын албан хаагчид ямар, ямар чиглэлээр бэлтгэгддэг вэ?
- Ажилд авах шалгуурууд (боловсрол ба хувийн байдал) ямар вэ?
- Мэргэжлээ дээшлүүлэх ямар боломж байдаг вэ? Энэ боломжийг ашигладаг уу?

### **Нэмж унших материал**

- “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”
- Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм
- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий илтгэл зүйл 23, зүйл 56.

## **ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД СААТУУЛАХ**

Цагдаагийн байгууллагад саатуулах явдал богино хугацаатай, хоног өдрөөр гэхээсээ цагаар тооцогдох нь олонтаа. Саатуулагдсан хугацаа 24 цагаас хэтэрсэн тохиолдолд цагдаад баривчлагдсан этгээдийг цаашид хорих уу, эсхүл суллан тавих уу гэдэг асуудлыг шүүгч шийдвэрлэнэ. Тийм боловч баривчлагдсан эхний цагуудад хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөх аюул их байдаг.

Цагдаагийн байгууллагад хүмүүс богино хугацаагаар хоригддог. Энд хорих нөхцөл материаллаг талаасаа бараг байхгүйтэй адил.

Энд хүний эрхийг хангах баталгаа онцгой ач холбогдолтой болдог.

### **Цагдаагийн байгууллагад саатуулан хорих**

§ Аюулгүй байдлын үндсэн баталгаа

§ Баримтжуулалт

§ Байцаалт

§ Мэдээлэл

§ Материаллаг нөхцөл

## **АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН БАТАЛГАА**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо цагдаагийн байгууллагад саатуулагдсан этгээдийн хүний эрхийн гурван асуудалд онцгой чухал ач холбогдол өгдөг.

Энэ нь өөрийн сонголтоор гуравдагч этгээдэд баривчлагдсан тухайгаа мэдээлэх эрх (гэр бүл, найз нөхөд, элчин, консулын газар), өмгөөлөгч дуудах эрх ба өөрийн үзэмжээр эмчид үзүүлэхийг шаардах (урьд нь цагдаагийн байгууллагын дуудлагаар ирсэн эмчид үзүүлсэн эсэхээс үл хамаарна) эрхтэй. Эдгээр эрхүүд нь тухайн эрх зүйн системд юу гэж нэрлэдгээс үл шалтгаалан хоригдож эхэлсэн мөчөөс эхлэн саатуулагдсан этгээдийг хэрцгий, хүнлэг бус харьцаанаас хамгаалах үндсэн гурван баталгаа болдог.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 36)

Хүнийг дөнгөж хорьсны дараа айлган сүрдүүлэх, бие махбодийн хүчирхийлэл үйлдэх эрсдэл өндөр байдаг. Тиймээс цагдаагийн байгууллагад саатуулагдсан этгээд энэ үедээ өмгөөлөгч авах боломжтой байх нь түүнийг хүчирхийллээс хамгаалах үндсэн баталгаа болно. Энэхүү боломж нь хоригдсон этгээдэд хүчирхийлэл үйлдэх хандлагатай цагдаа нарын үйлчлэлийг сааруулахаас гадна хүчирхийлэл нэгэнт үйлдэгдсэн болон үйлдэгдэж байвал өмгөөлөгч холбогдох арга хэмжээ авах бололцоотой. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хороо цагдаагийн мөрдөн байцаалтын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс саатуулагдсан этгээдийг түүний дуудсан өмгөөлөгчтэй уулзуулахыг тодорхой хугацаагаар хойшлуулж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ энэ нь мөрдөн байцаалтын явцад өмгөөлөгч авах эрхийг нь бүрмөсөн хязгаарлана гэсэн үг биш. Саатуулагдсан этгээдийн дуудсан өмгөөлөгчийг уулзуулах боломжгүй тохиолдолд өөр чөлөөт өмгөөлөгч авах эрх нь хангагдах ёстой.

Өмгөөлөгч авах эрх нь өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах эрхийг мөн хангана. Зарчмын хувьд саатуулагдсан этгээд цагдаагийн ямар ч байцаалтын үед өмгөөлөгчтэй байх ёстой. Энэ нь мэдээж яаралтай асуудлаар саатуулагдсан этгээдийг байцаах шаардлага гарч, өмгөөлөгч нь нэн даруй хүрэлцэн ирэх боломжгүй байх тохиолдолд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд саад болох ёсгүй. Эсхүл байцаалтын ажиллагаанд саад болж буй өмгөөлөгчийг сольж болохгүй гэсэн үг бас биш.

Зөвхөн сэжигтэн төдийгүй цагдаагийн байгууллагад очих шаардлага гарсан бусад этгээд, гэрч өмгөөлөгч авах эрхтэй.

Өмгөөлөгч авах эрхийг амьдралд бүрэн хэрэгжүүлэхийн тулд өмгөөлөгчид төлбөр төлөх чадваргүй этгээдэд ч энэ эрхээ эдлэх боломж олгох ёстой.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 41)

Хоригдож буй этгээд эмчид хандах албан ёсны боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн этгээд эмчид үзүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эмч саадгүй ирэх ёстой. Цагдаагийн ажилтнууд ийм шаардлагыг хайхралгүй өнгөрөөж болохгүй. Хоригдогч хүсвэл өөрийн сонгосон эмчид үзүүлэх (урьд нь цагдаагийн газрын дуудсан эмчид үзүүлсэн байсан ч) эрхтэй.

Саатуулагдсан этгээдэд эмчийн үзлэг хийхдээ цагдаагийн ажилтнуудад сонсогдохооргүй газар, түүнчлэн эмч тодорхой тохиолдолд өөр шаардлага тавиагүй бол ажилтнуудын нүднээс далд газар хийнэ.

Мөн саатуулагдаж байгаад суллагдсан этгээд шүүхэд очоогүй бол эмнэлгийн үзлэгийн (шүүх эмнэлгийн албан ёсны магадлагаа) тухай баримтыг шууд шаардаж авах эрхтэй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Арванхоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 42)

Саатуулагдсан этгээд баривчлагдсан даруйдаа энэ тухайгаа гуравдагч этгээд буюу гэр бүл, найз нөхөд, бусад этгээдэд мэдэгдэх эрхтэй. Энэ эрх нь баталгаажсан байх ёстой. Энэ эрхийг цагдаагийн мөрдөн байцаалтын хууль ёсны эрх ашгийн үүднээс тодорхой хэмжээгээр хязгаарлаж болох юм гэдгийг Эрүүдэн шүүхийн эсрэг Европын хороо хүлээн зөвшөөрч байна. Гэвч ийм хязгаарлалт хийхдээ цаг хугацааг нарийвчлан тодорхой тогтоож, холбогдох баталгаагаар хангах ёстой. Жишээ нь: баривчлагдсан тухайгаа мэдээлэхийг татгалзаж хойшлуулахдаа энэ тухай бичгээр баримт үйлдэж шалтгааныг нь тодорхой дурьдах ба тухайн цагдаагийн байгууллагын энэ хэрэгт холбогдолгүй удирдах албан тушаалтан, эсхүл прокурор гарын үсэг зурж баталсан байна.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 43)

---

**Анхаарах зүйл:** Саатуулагдсан эдгээдэд хандах цагдаагийн ажилтнуудын эрх мэдлийг тодорхой шалгуураар хязгаарлаж, гуравдагч этгээдэд мэдээлэх, өмгөөлөгч авах, эмчид үзүүлэх боломжтой байх баталгааг хангаж өгөх ёстой.

---

### **Шалгах асуулт**

- Саатуулагдсан этгээдэд гэр бүл болон гуравдагч этгээдэд баривчлагдсан тухайгаа мэдээлэх боломж байсан уу?
- Өмгөөлөгч авах боломж бий юу?
- Эмчийн үзлэгт орсон уу?
- Цагдаагийн байгууллагад саатуулах дээд хугацаа мөрдөгдсөн үү?
- Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс тусдаа хоригддог уу?
- Насанд хүрээгүй хүмүүс насанд хүрэгсдээс тусдаа юу?
- Бусад хоригдогсдоос хамгаалагдах арга хэмжээ авагддаг уу?

### **БАРИМТЖУУЛАЛТ**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 40:

Баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон бүх этгээдийг бүртгэж тоолдог нэгдсэн тогтолцоотой байвал нэг талаас тухайн этгээдийн эрхийг хамгаалах найдвартай баталгаа бүрдэж, нөгөө талаас цагдаагийн ажилтны ажил тодорхой хэмжээгээр хөнгөлөгдөх юм. Энэ бүртгэлд баривчлагдсан этгээд хэзээ хоригдсон, ямар шалтгаанаар ийм арга хэмжээ авагдсан, эрхийг нь хэзээ танилцуулсан, биедээ ямар нэгэн гэмтлийн шинжтэй эсэх, сэтгэцийн эмгэгийн ямар нэгэн шинж илэрсэн эсэх, төрөл садан, зөвлөх, өмгөөлөгчтэй хэзээ уулзсан, хэзээ эргэлт авсан, хэзээ хооллосон, хэзээ байцаасан, хэзээ шилжүүлсэн болон хэзээ сулласан гэх зэргээр тухайн этгээдтэй холбоотой бүх асуудлыг тусгасан байвал зохино. Саатуулагдсан этгээд ямар өмч эзэмшдэг, эсхүл эрхийнх нь тухай танилцуулсан эсэх болон эрхээ эдэлсэн, эдлэхээс татгалзсан зэрэг тодорхой асуудлуудаар тухайн этгээдийн гарын үсгийг авах бөгөөд гарын үсгээ зураагүй бол шалтгааныг заана. Үүнээс гадна саатуулагдсан этгээдийн өмгөөлөгч энэ бүртгэлийг үзэх боломжтой байх ёстой.

---

*Анхаарах зүйл: Бүртгэлд хоригдсон этгээдийн талаар чухал мэдээлэл бичгээр хийгдэж хадгалагддаг учраас мэдээлэл боловсруулахад чухал боловч юуны өмнө баривчлагдсан цаг хугацаа, шалтгаан, байцаалт, шилжүүлэг, гуравдагч этгээдэд мэдээлэх гэх зэргээр баривчлан саатуулах үйл ажиллагааны бүх мэдээллийг зайлшгүй шалган тэмдэглэх шаардлагатай.*

---

### **Шалгах асуулт**

- Дараах мэдээллүүд бүртгэлд орсон уу? Үүнд: хэзээ баривчлагдсан, хэзээ байцаагдсан, хэзээ шилжүүлсэн болон сулласан, гуравдагч этгээдэд хэзээ мэдэгдсэн, тухайн этгээдэд эрхийг нь танилцуулсан уу? Хэзээ эмчийн үзлэгт орсон, хэзээ өмгөөлөгч уулзсан, хэзээ гуравдагч этгээдтэй уулзсан, хоол хүнсний хангамж ямар вэ? Хэзээ ямар хоол хүнс өгдөг вэ?
- Тэмдэглэлийг тогтмол, нарийн тодорхой хөтөлдөг үү? Саатуулах дээд хугацаа мөрдөгдсөн үү?



## **БАЙЦААЛТ**

1. Саатуулагдсан болон хоригдсон этгээдийг байцаах, байцаалтын хоорондох завсарлагааны үргэлжлэх хугацаа түүнчлэн байцаалт авч байгаа албан тушаалтан, түүнд оролцож байгаа бусад хүмүүсийн овог нэрийг хуульд заасан хэлбэрээр тусгаж баталгаажуулна.

2. Хуульд заасан тохиолдолд саатуулагдсан болон хоригдсон этгээд, түүний өмгөөлөгч энэ зарчмын 1 дүгээр хэсэгт заасан мэдээлэл авах эрх эдэлнэ.

( "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц" -ын 23 дугаар зарчим)

Байцаалт хийх тухай цагдаагийн ажилтанд зориулсан маш тодорхой журам буюу удирдамж байх нь зүйтэй гэдгийг Эрүүдэн шүүхийн эсрэг Европын хороо үзэж байна. Журам буюу удирдамжид дараах асуудлуудыг тусгах ёстой. Үүнд: байцаалтад оролцож байгаа хүний тухай (нэр, хувийн дугаар г.м.) мэдээлэх, байцаалт явуулах зөвшөөрөгдсөн хугацаа, байцаалтын хооронд амрах хугацаа, байцаалт дундуур завсарлага хийх хугацаа, байцаалт хийхээр зөвшөөрөгдсөн газар, саатуулагдсан этгээдийг зогсож байцаалт өгөхийг шаардах боломж, согтуу болон хар тамхинд мансуурсан этгээдийг байцаах г.м. Байцаалт эхэлсэн болон дууссан хугацаа, байцаалтын үед саатуулагдсан этгээдийн гаргасан бүх хүсэлт, байцаалтын үеэр байлцсан бүх хүмүүсийн тухай тэмдэглэлийг заавал хөтлөхийг шаардах нь зүйтэй.

( Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 39)

Цагдаагийн байцаалтын тухай аудио, видео бичлэг хийх нь саатуулагдсан этгээдэд хэрцгий хандахгүй байх баталгаа болно. Ийм систем нэвтрүүлж байгаа улс орны тоо олон болж байгааг Хороо тэмдэглэхдээ таатай байна. Бичлэг хийх нь байцаалтын явцыг бүрэн дүүрэн буулгаж авах, хэрцгий, хүнлэг бус харьцсан тухай гомдлыг мөрдөн шалгах ажлыг ихээхэн хөнгөрүүлнэ. Түүнчлэн бичлэг нь цагдаагийн ажилтан: Хэрцгий, хүнлэг бус харьцсан, баривчлагдсан сэжигтэн яллагдагчид хүч хэрэглэсэн, сэтгэл зүйн дарамтанд оруулсан хэмээн гүтгэгдсэн тохиолдолд цагдаагийн ажилтны буруугүйг нотлоход ашигтай.

Нөгөөтэйгүүр ийм бичлэг нь түрүүчийн байцаалтанд мэдүүлснээсээ буцсан яллагдагчид боломж олгохгүй.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 36)

Гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг мэргэжлийн бэлтгэл хангасан ажилтан байцаана. Юуны өмнө байцаалтынхаа зорилгыг маш тодорхой тогтооно. Байцаалтын зорилго нь мөрдөн байцаагчийн хүсэж байгаа зүйлийг сэжигтнээр хэлүүлэхэд бус гагцхүү мөрдөгдөж байгаа гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход шаардлагатай мэдээлэл авахад оршино. Үүний тулд мөрдөн байцаагч мэргэжлийн зохих бэлтгэлтэй байхаас гадна сэжигтнийг байцаах байцаалтын

Хоригдогсдын **ХҮН** гэсэн нэр төрийг нь **ХҮНДЭТГЭН** харьцах ёстой \_\_\_\_\_

кодекссоо зөв хийж чаддаг байх нь чухал.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 34)

---

***Анхаарах зүйл:** Хүмүүст эрүү шүүлт тулгах зорилгуудын нэг нь хэргийг нь хүлээлгэх, өөрийн болон бусдын эсрэг мэлдүүлэг өгөхийг шаардах явдал байдаг. Иймд байцаалтын үеэр өмгөөлөгч байлцуулах, хяналтгүйгээр байцаалт явуулах явдал гаргахгүй байх ёстой. Мөрдөн байцаалтын үеэр протокол тэмдэглэл хөтөлнө.*

---

### **Шалгах асуулт**

- Тухайн этгээдэд хүч хэрэглэсэн үү? Тийм бол баривчлах үед үү? Байцаалт явуулахдаа юу?
- Доромжлох, айлган сүрдүүлэх зэргээр сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байсан уу? Одоо үргэлжилсээр байгаа юу?
- Байцаалтыг ямар нөхцөлд явуулдаг вэ?
- Байцаагдаж байгаа этгээдэд ажилтан өөрийгөө хэн болох тайлбар хийсэн үү?
- Байцаалт ямар хугацаагаар үргэлжилдэг вэ? Байцаалт явуулах үеэр завсарлаж байна уу?

### **МЭДЭЭЛЭЛ**

Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтгааныг баривчлах үед мэдээлж аливаа сонгосон ялыг түүнд нэн даруй мэдэгдэх ёстой.

(“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц”-ын 10 дугаар зарчим)

Хоригдсон этгээд өөрийн эдлэх ёстой эрхээ мэдэхгүй бол эрх нь үнэ цэнээ алддаг. Тиймээс цагдаагийн газар саатуулагдсан этгээдэд түүнд ойлгогдох хэлээр эрхийг нь нэн даруй танилцуулах шаардлагатай. Энэ эрхийг хангахын тулд цагдаагийн байгууллага саатуулагдсан этгээдэд түүний эрхийг баталгаажуулсан гарын авлага өгөх нь зүйтэй. Саатуулагдсан этгээд эрхтэйгээ танилцсан тухайгаа баталгаажуулж гарын үсэг зурсан байвал зохино.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 44)

---

***Анхаарах зүйл:** Баривчлагдсан этгээд баривчилсан шалтгааныг мэдэх, өөрийн эрхтэй танилцах эрхтэй байдаг. Эдгээр мэдээллийг өгөхдөө баривчлагдсан этгээдэд ойлгомжтой хэлээр танилцуулна. Баривчлагдсан этгээд бичиг мэддэггүй бол амаар танилцуулна.*

---

### **Шалгах асуулт**

- Ямар шалтгаанаар баривчилснаа нэн даруй мэдэгдсэн үү?
- Эрхийг нь танилцуулсан уу? Амаар уу, бичгээр үү?
- Ойлгомжтой хэл дээр байсан уу?

### **МАТЕРИАЛЛАГ НӨХЦӨЛ**

Цагдаагийн хэсэгт хорих өрөөнүүд нь цэвэрхэн, хоригдож байгаа хүмүүст хангалттай зайтай, шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй (байгалийн гэрлийг илүүд үзнэ) байвал зохино. Амрах боломж олгосон сандал, ширээтэй (сандал, ширээний хөлийг нь шаланд бэхэлсэн байна), хонох хүнд зориулагдсан цэвэр гудас, хөнжилтэй байна. Цагдаагийн байгууллагад саатуулагдсан этгээд боломжийн нөхцөлд бие засах, нүүр гараа угаах боломжоор хангагдана. Ундны цэвэр усаар саадгүй хангагдах ба хоол хүнсийг тогтоосон цагт нь өгнө. Халуун хоолыг өдөрт ядаж нэг удаа өгөх ёстой. 24 цаг болон түүнээс урт хугацаагаар саатуулагдсан этгээдийг өдөр бүр нарлагаанд гаргах ёстой.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 2001 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Арванхоёр дахь Ерөнхий Илтгэл, зүйл 47)

Цагдаагийн газар хорих өрөө ямар хэмжээтэй байвал зохистойг тогтоох нь түвэгтэй асуудал юм. Учир нь энэ асуудал их олон хүчин зүйлээс шалтгаална. Гэхдээ Хорооны төлөөлөгчид үлгэрчилсэн зөвлөмж шаардлагатай гэж үзээд дараах шалгуурыг тогтоожээ. Энэ шалгуурыг стандарт гэж үзэх хэрэгтэй. Энэ нь ойролцоогоор 7 метр квадрат. Нэг хананаас нөгөө хана хүртэл 2 метр, түүнээс их байсан ч болно. Тааз хүртэл 2.5 метр байна.

(Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын хорооны 1991 оны 1 сарын 1-нээс 12 сарын 31 хүртэл хугацаанд хийсэн үйл ажиллагааны тухай Хоёрдахь Ерөнхий Илтгэл, зүйл 43)

***Анхаарах зүйл:** Саатуулах хугацаа богино байдаг учраас хорих байрнаас хэмжээгээрээ бага байж болно. Саатуулах байр нь байгалийн гэрэлтүүлэгтэй, агааржуулалттай, дулаан нь тухайн улирлын байдал болон цаг агаарын байдалд зохицсон байх ёстой. Саатуулагдсан этгээд тэнд хоноглохоор бол гудас, хөнжил, бие засах асуудлыг шийдвэрлэх өгөх ёстой.*

### **Шалгах асуулт**

- Саатуулах байранд хэдэн хүн хоригддог вэ? Хэт дүүрэх хандлага бий юу?
- Байгалийн гэрэлтүүлэгтэй юу?
- Дулаан нь тохирч байна уу?
- Сандал, ширээ, гудас байна уу?
- Хоол хүнс, халуун хоол өгсөн үү?
- Ундны цэвэр ус уух боломж байна уу?
- Бие засах газар ашиглах боломж хэр вэ?

### **Нэмж унших материал**

- ХЗДХ-ийн сайдын 2008 оны 50 тоот тушаал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц
- НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдөр 43/173 дугаар тогтоолоор баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмын цогц”
- Европын Зөвлөлөөс 1950 онд баталсан Европын Хүний Эрхийн Конвенц
- Европын зөвлөлийн орнуудын Сайд нарын Хорооноос 1987 оны 2 дугаар сарын 17-нд баталсан Европын шоронгийн дүрэм,
- Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь: 2005 он, Эмнести Интернэшнл
- Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын хүний эрхийн талаар баримтлах 10 үндсэн жишиг хэмжээ: 2000 он, Эмнести Интернэшнл
- Цагдаагийн зэвсэг тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тактик, 2006 он, З. Цэрэнбат
- Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь: 2005 он, Эмнести Интернэшнл
- Хүний эрх ба урьдчилан хорих ажиллагаа: НҮБ, Хүний эрхийн дээд комиссарын газар, 1994 он
- Цагдаагийн мэргэжлийн сургалт: 2003 он, ЦЕГ
- Хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд холбогдолтой эрх зүйн баримт бичгийн эмхтгэл: 2001 он, ШШБЕГ
- Хүний эрх ба хууль сахиулах нь: 2005 он, НҮБ

### **Ашигласан материал**

- Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь: 2005 он, Эмнести Интернэшнл
- Хорих, цагдан хорих төвд хийх мониторинг: ТББ-уудад зориулсан гарын авлага, 2006 он
- Хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд холбогдолтой эрх зүйн баримт бичгийн эмхтгэл: 2001 он, ШШБЕГ
- Хүний эрх ба хууль сахиулах нь: 2005 он, НҮБ
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, 2008 он

ОИХ.МН  
СУДАЛГААНЫ САН